

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Л.ХАШ-ЭРДЭНИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН  
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ  
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Аймгийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

**Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	91.2	63.8

**1. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хариуцсан ажлын хүрээнд сургалтад хамрагдах		14.8
2.	Хариуцсан салбарын байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажлын байрандаа суралцах		14.8
<b>Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо</b>			<b>14.8</b>

**2. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	14.8
2.	Удирдан зохион байгуулах	15.0
3.	Асуудал шийдвэрлэх	15.0
4.	Манлайлах	14.5
5.	Багаар ажиллах	14.5
6.	Харилцаа	14.8
<b>Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо</b>		<b>14.7</b>

**3. Гүйцэтгэлийн үнэлгээ**

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	63.8
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	14.8
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	14.7
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
<b>Нийт оноо =</b>		<b>93.2</b>

( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо

**Үнэлгээ өгсөн:**

АЙМГИЙГ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

20...оны...сарын...өдөр

Төсвийн шууд захирагч

Ш.ЭРДЭНЭБАТ

**Үнэлгээтэй танилцаж,  
зөвшөөрсөн:**

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

20...оны...сарын...өдөр

Нэгжийн дарга:

П.ХАШ-ЭРДЭНЭ

ХӨГӨЛИЙН БОДЛОГ, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨГӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2024.12.05

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
<p align="center"><b>НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ</b></p> <p align="center">Зорилт 1 Төрийн болон нутгийн худалдан авах ажиллагааны талаар</p>					
1.1	<p>Улс, орон нутгийн төсвийн болон ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах, тайлагналтад хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан, зөрчил маргаан гаргуулахгүй байх хуулийн хэрэгжилтийг мөрдөн үр дүнтэй ажиллах</p>	Төсөл арга хэмжээний тоо	92	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг ажиллагаандаа мөрдөн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 120 төсөл, арга хэмжээнээс 17-н төсөл арга хэмжээг шууд худалдан авалтаар, үлдсэн 103 төсөл арга хэмжээг тендер шалгаруулалтаар зохион байгуулахаар баталсан. Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөнд тусгагдсан нийт төсөл арга хэмжээнээс 99 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын үнэлгээний хороо байгуулагдаж, тендер шалгаруулалтын нээлт хийгдэж цахим системд үр дүнг нийтэлсэн нийт 84, үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулсан 15 төсөл арга хэмжээ байна. Мөн 2024 онд худалдан авах ажиллагаатай холбоотой шүүхийн шатанд 1, Сангийн яаманд 4, нийт 5 гомдол, маргаан гарсныг Шүүх болон Сангийн яам хянан үзээд Захиалагчийн талд шийдвэрлэсэн байна.	90
1.2	<p>Улс, орон нутгийн төсөв, орон нутгийн авто замын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хууль, журамд заасан хугацаанд төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, түүнд хяналт тавих</p>	Хэрэгжилтийн хувь	97	Тус аймагт УТХО-аар хэрэгжүүлэхээр батлагдсан нийт төсөл, арга хэмжээнээс орон нутагт эрх шилжүүлсэн 9 төсөл арга хэмжээ байгаа бөгөөд үүнээс 7 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймгийн Худалдан авах ажиллагааны газарт зарлаж, гүйцэтгэгч шалгаран, гэрээ байгуулагдсан, 1 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зарлаж, нээлт хийхээр хүлээгдэж, 1 төсөл арга хэмжээ нь он дамжин хэрэгжиж байгаа тул нэмэлт гэрээ байгуулан ажиллаж байна. Харин орон нутгийн төсөв, орон нутгийн авто замын сан, аймгийн орон	90

				<p>нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 71 дүгээр тогтоолоор анх баталсан бөгөөд 2024 оны 28, 39 дүгээр тогтоолуудаар тус тус тодотгол хийсэн. Тайлант үеийн байдлаар ОНТХО-аар хэрэгжүүлж буй нийт 20 төсөл арга хэмжээнээс нийт 15 төсөл, арга хэмжээний санхүүжилт 1,419.9 сая төгрөгийг, ОНАЗС-аар хэрэгжиж буй нийт 3 төсөл, арга хэмжээний санхүүжилт 345.7 сая төгрөгийг, ОНХС-аар хэрэгжиж буй нийт 56 төсөл арга хэмжээний санхүүжилт 2,321.7 сая төгрөгийг тус тус олголоо. Мөн 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан нийт төсөл, арга хэмжээнээс ОНТХО-ын 6, ОНАЗС-ийн 2, ОНХС-ийн 18 төсөл, арга хэмжээг он дамжуулан хэрэгжүүлэхээр тус тус төвлөвлөв.</p>	
<p>Зорилт 2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын илрэлийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, орд, илэрцийн мэдээллийн санг үүсгэж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нөөцийг тогтоон, олборлолтын үйл ажиллагааг эхлүүлнэ.</p>		<p>Хяналт шалгалтын тоо</p>	<p>7 удаа</p>	<p>Цагдаагийн газар болон хууль хяналтын байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран 2 сумын нутагт хууль бусаар газрын хэвлийг ашиглаж байгаа байдалд 20 гаруй удаа хяналт шалгалт хийж, хууль бусаар ашигт малтмал олборлосон гэх 1 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, 13 зөрчилд Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцон, 1 сумын 2 газарт цагдаагийн байнгын эргүүл пост ажиллуулж байна. Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 80%-аар, зөрчил 50%-аар буурсан үзүүлэлттэй байна</p>	<p>100</p>
<p>2.1</p>	<p>Хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт хийж эрсдэлийг бууруулан, хуулийн байгууллагуудтай хамтарч ажиллах</p>	<p>шийдвэрлэсэн өргөдлийн тоо</p>	<p>16</p>	<p>Тайлант хугацаанд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 11 өргөдөл хүлээн авч анхан шатны шүүлт хийж хүсэлтийг Ашигт малтмал газрын тосны газарт уламжилан дүгнэлт гаргуулж 11 өргөдлийг шийдвэрлэн хариуг хүргүүлээ.Тайлант хугацаанд 1 аж ахуйн нэгжид түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгов.</p>	<p>100</p>
<p>2.2</p>	<p>Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг шийдвэрлэж барилгын материалын түүхий эдийн олборлолтын үйл ажиллагааг идэвхжүүлэх</p>				

2.3	Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах	АМГТГ-т уламжилсан хүсэлтийн тоо	7	Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын хэрэгжилтийг хангаж, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох хүсэлт 4 сумын 11 талбайд ирүүлснийг Ашигт малтмал газрын тосны газарт уламжилж Дарив сумын талбайд боломжтой гэсэн дүгнэлт ирүүлсний дагуу 2 нөхөрлөл ажиллаж байна.	100
2.4	Геологи уул уурхай, хий газрын тосны чиглэлээр хийсэн өмнөх шалгалтуудын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар өгсөн албан шаардлагын биелэлтийн хэрэгжилттэд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх	Илрүүлсэн зөрчил арилгалтын хувь, %	-	Аймгийн Засаг даргын 2024 оны А/108, А/620 дугаар захирамжуудаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, 2 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт бус болон гүйцэтгэлийн шалгалт хийж, 9 заалт бүхий 1 албан шаардлага хүргүүлж ажилласан бөгөөд биелэлт 60%-тай, 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ тооцов.	50
2.5	Газрын хэвлий болон Ашигт малтмалын тухай хуулиудыг зөрсөн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэх	Зөрчил гомдлыг шийдвэрлсэн эсэх: 1-Тийм 0-Үгүй	1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны салбарын хяналтын газраас болон аймгийн Цагдаагийн газраас харьяаллын дагуу шалгуулахаар ирүүлсэн газрын хэвлийг хууль бусаар ашигласан гэх 25 иргэн, бичил уурхайн журам зөрсөн гэх 1 албан тушаалтан, уулын ажлын тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь ирүүлээгүй гэх 4 ААН-д холбогдох зөрчлийн 20 гомдол мэдээллийг хүлээн авч хялбаршуулсан журмаар зөрчлийн 9 зөрчлийг шийдвэрлэж, 11 гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзсан бөгөөд 3 аж ахуйн нэгж, 12 иргэнд 22,300 (22сая 300 мянган) мянган төгрөгийн торгууль ноогдуулсан.	100
Зорилт 3. Аялал жуулчлалын салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, ур чадварыг нэмэгдүүлнэ.					
3.1.	Туульсын хаан, Жангар фестиваль зэрэг аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг төр хувийн хэвшилтэй хамтран жилд 2 удаа зохион байгуулах.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	Элсний фестиваль аялал жуулчлалын эвент арга хэмжээг Дөргөний эрэг дээрх 24/7 "Жангар фестиваль 3/0" нэрээр Хөхморьт сумын Дөргөн нуурын эрэг дээр зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Эвермонгол, Улаанбаатар хот, Ховд, Увс, Завхан, Архангай аймаг Говь-Алтай аймгийн сум бүрээс 2100 залуус ирж оролцсон. Тус арга хэмжээ зохион байгуулагдсанаар байгалийн болон тусгай сонирхлын аялал жуулчлал хөгжих, алслагдсан орон нутагт амьдарч буй залуучуудын нийгмийн харилцааг сайжруулах гэх мэт олон зэрэг үр дүн гарсан.	100

				<p>Ховд аймгийн "Мөнгөлөг шагнуула-2024" зохион байгуулагдлаа. Энэхүү арга хэмжээнд холбогдох албан байгууллагууд хамтран оролцож, Хантайширын отог байгуулан Жангар тууль хайлах арга хэмжээг сурталчилан Алтай нутгийнхаа угсаатны соёлын биет болон биет бус өвийг баруун монголчууддаа сурталчилан таниуллаа.</p>	
3.2.	<p>Аялал жуулчлалын бүс дагуух гол, нуурын нөлөөллийг бууруулах, хамгаалах зорилгоор контент бэлтгэн олон нийтэд сурталчилах</p>	<p>Бэлтгэсэн контентийн тоо</p>	-	<p>Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 21.0 сая төгрөгийн санхүүжилтээр нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 1000 ширхэг гарын авлага хэвлүүлэн тарааж, аймгийн түүхэн 4 боть ном, альбумыг хэвлүүлж түгээлээ. Мөн аялал жуулчлалын бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, гол нуурын нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн 21.0 сая төгрөгөөр нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор иргэдэд мэдээлэл түгээх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах ажлын гүйцэтгэгчээр "Соёмбопринтинг" ХХК шалгарч бүрэн хийж гүйцэтгэлээ.</p>	100
3.3.	<p>Жуулчид ихээр зорин ирж буй Дөргөн нуурийн урд хэсэг болох Хөхморьт сумын нутаг аялал жуулчлалын отоглох цэг байгуулах ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах</p>	<p>Отоглох цэгийн тоо</p>	-	<p>Улсын төсвийн 376.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хөхморьт сумын Цоохор багт байрлах Дөргөн нуурын захад "Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг" байгуулах ажлын гүйцэтгэгчээр "Хос Гандирс" ХХК шалгарч, 70 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.</p>	70
	<p>Зорилт.4 "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлт"-ийн бодлогын аж үйлдвэржилт болон хот хөдөөгийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд</p>				
4.1.	<p>"Алтайн малчдын түншлэл" төслийн ажлыг эрчимжүүлэн зөвлөх үйлчилгээний тайланд үндэслэн ТЭЗҮ боловсруулах ажлын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэн хэрэгжүүлэх</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>Дотоодын 5 үйлдвэр, Өвөр Монголын өөртөө засах орны Шилийн гол 3 үйлдвэрт туршлага судлах ажлыг зохион байгуулсан</p>	<p>Малын гаралтай түүхий эд ноос, ноолуур угаах, ярьс шир боловсруулах, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулж, үйлдвэрлэх дундаас дээш хүчин чадалтай үйлдвэрүүдийг байгуулан, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн болгон экспортлох, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилготой "Алтайн малчдын түншлэл" төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Мөн малчдыг мэдлэг мэдээллээр хангах чиглэлээр Шинэ хоршоо хөдөлгөөний баруун бүсийн уулзалтад 18 сумын 88 багийн малчдын төлөөллийг оролцуулсан. Тус төслийн хүрээнд 2022-2023 онд хийж хэрэгжүүлсэн ажил болон төслийн үр дүнг дүгнэх уулзалтыг 06 сарын 09-ний өдөр зохион байгуулан ажлын хэсгийн 88 багийн малчдын төлөөлөлтэй уулзалт хийж, санал солилцлоо.</p>	100

4.2	Өрх бүрт өсөлт, иргэн бүрт өрлого арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Малжуулсан өрхийн тоо	110 залуу малчин өрхийг малжуулсан	Тайлант онд нийт шинээр гэр бүл болгох 38 залуу малчин өрх болон цөөн малтай малгүй болсон нийт 43 малчин өрх үүнд: Баянтоорой 25, Цээл 12, Баян-Уул 8 малчин өрхийг амийгийн орон нутгийн төсөөс санхүүжүүлэн нийт 81 өрхийг малжуулан ажилласан.	100
4.3	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх сургалтыг зохион байгуулах	Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо	1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 2024 оны 04 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд мал зүйч мэргэжилтнүүдэд "Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний хяналтын улсын байцаагч"-ийн эрх олгох, чадавхижуулах сургалтыг зохион байгуулсан. Сургалтад аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга болон сумдын Хөдөө аж ахуйн тасгийн "Мал аж ахуйн үйлдвэрлэл төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал" хариуцсан мал зүйч мэргэжилтнүүд хамрагдсан. Сургалтын үеэр 11 сумын мал зүйч мэргэжилтнүүдэд улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэгийг олгосон. Мөн ХХААХҮЯ-аас малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэлтийн сургалтадйг зохион байгуулж, тус сургалт аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газрын мал аж ахуйн тасгийн Малын генетик нөөцийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, ялган тэмдэглэгээ хариуцсан мэргэжилтэн хамрагдсан.	100

Зорилт 5. Газар тариалангийн салбарт

5.1	Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэн ий тариалалтыг нэмэгдүүлэх "Газар тариалан, жимс жимсгэнэ" төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Тариалсан талбайн хэмжээ, га	1287,1 га	Аймгийн хэмжээнд нийт 1328,6 га-д тариалалт хийгдэж, 3062,3 тн ургац хураан авлаа.	100
	Өрхийн тариалалтыг нэмэгдүүлэх	Тариалсан талбайн хэмжээ, га	-	Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын "Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг" төслийн хүрээнд зорилтот Бигэр, Төгрөг сумдын 500 малчин өрхөд ногоон тэжээл тарих арга технологийн сургалтыг 2024 оны 02	100

				<p>дугаар сарын 27-ны өдрөөс 04 дүгээр сарын 01-ний хооронд зохион байгууллаа.</p> <p>Тайшир, Шарга, Есөнбулаг сумдын 5 малчин нийт 10 га талбайд ногоон тэжээл тариалан 22.5 тн ургац хураан аваад байна.</p> <p>"Шинэ Хоршоо-Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд 125 малчин ногоон тэжээл тарих зориулалтаар зээлд хамрагдсан байна.</p>	
5.2	<p>Жаргалан сумын Цахирын усралтын системийг шинээр барьж, Халиун сумын Ёлтонгийн усралтын системийг шинэчлэн, засварлаж, тариалалт эхлүүлэх</p>	<p>Тариалалт хийгдсэн талбайн хэмжээ, га</p>	<p>Засварын ажил хийгдэж эхэлсэн</p>	<p>Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй "Хүнсний ногооны үйлдвэрлэл усалгаатай хөдөө аж ахуй төслийн дэд төсөл Халиун сумын Ёлтон, Жаргалан сумын Цахирын усралтын системүүдийг шинэчлэх, сэргээн засварлах усралтын системийн ус татамжийн барилга, гол суваг, усан сан (хиймэл нуур), гол хоолой, усралтын далд сүлжээ, түүн дээрх барилгууд болон бороожуулах машин гэсэн үндсэн хэсгүүдийн техникийг шийдвэрлэн, толгойн барилга гол суваг, шуудууг бүрэн засварлан дууссан ба Цахилгаан дамжуулах шугам сүлжээний барилгын ажлын бүрэн орхигдсонтой холбоотой гэрээг 2025 оны 09 сарын 20-ны өдрийг хүртэл сунгаж цахилгааны ажлын нэмэлт гэрээ байгуулан ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 05 сарын 20 гэхэд улсын комисст хүлээлгэн өгөхөөр төлөвлөн хүлээгдэж байна.</p>	70
Зорилт 6. Эрүүл хүнс арга хэмжээг хэрэгжүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангаж, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.					
6.1	<p>Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах хувийн хэвшлийг дэмжиж ажиллах</p>	<p>Байгуулагдсан үйлдвэрийн тоо</p>	<p>Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах 3 үйлдвэр цех үйл ажиллагаа явуулж байна.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын "Хүнсний хувьсгал", "Шинэ хоршоо чинээлэг малчин" үндэсний хөдөлгөөний хүрээнд 18 суманд 500 гаруй хоршоо шинээр байгуулагдсан ба 360 хоршооны 1495 малчин өрхөд 49,6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг таван жилийн хугацаатайгаар олгосон байна.</p> <p>Үүнээс сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 96 хоршоо зээл аваад байна.</p>	70
6.2	<p>УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хүнсний боловсруулах үйлдвэрт олгосон зээлийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих</p>	<p>Хүнсний боловсруулах үйлдвэрт олгосон зээлийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих тоо</p>	<p>-</p>	<p>УИХ-ын 36 дугаар тогтоолын хүрээнд хүнсний боловсруулах үйлдвэрт олгох зээл авахаар 2023, 2024 онд нийт 19 аж ахуйн нэгж зээлийн хүсэлт, материалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн боловч банкны шалгуурыг хангаж зээл авсан аж ахуйн нэгж байхгүй байна.</p> <p>Мөн Монгол Улсын Засгийн газрын "Хүнсний хувьсгал", "Шинэ хоршоо чинээлэг малчин" үндэсний хөдөлгөөний</p>	50

				<p>хүрээнд мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 32 хоршоонд, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр 96 хоршоонд зээл олгосон байна.</p>	
6.3	<p>Мах боловсруулах үйлдвэр барих хувийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, махны экспортыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>Байгуулагдсан үйлдвэрийн тоо</p>	<p>Мах боловсруулах 3 үйлдвэр</p>	<p>Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас "Баян соёрхолт нутаг" ХХК-ийн Мах боловсруулах үйлдвэрийн зориулалттай 300,0 сая төгрөгийн төслийг сонгон шалгаруулж, зээлийг олгоод байна.</p>	70
6.4	<p>Нийтийн хоолны чанар хүртээмжийг сайжруулж, орон нутгийн онцлог бүхий уламжлалт брэнд хоол, идээ ундааг шинээр бий болгон хөгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх</p>	<p>Үйл ажиллаганы хэрэгжилтээр</p>		<p>Монгол үндэсний болон орон нутгийн онцлог бүхий хоол, идээ ундаа, сурталчлах, таниулах зорилгоор аймгийн "Аварга тогооч" шалгаруулах ажил, мэргэжлийн уралдааныг 11 дүгээр сарын 30-ны өдөр Хантайшир тогоочдын холбоотой хамтран зохион байгууллаа.</p> <p>Тус уралдаанд ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, эмнэлэг сувилалын тогооч нар, аймгийн хэмжээнд хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй нийтийн хоол, зоогийн газар, рестораны 58 тогооч нар 7 төрөлд өрсөлдөж аваргуудаа шалгаруулсан.</p> <p>Орхон аймагт зохион байгуулагдсан "Улсын аварга тогооч" шалгаруулах ажил мэргэжлийн уралдаанд 9 хүн оролцож хар хайрцаг буюу багийн төрлөөр мөнгөн медаль авсан.</p> <p>Дэлхийн тогооч нарын холбооноос зохион байгуулсан Азийн бүсийн 21 орны тогооч нарын чуулга уулзалтад тус аймгаас 8 хүн оролцож, тус арга хэмжээний үеэр орон нутгийн онцлогтой брэнд хоолны үзэсгэлэнг гаргаж ажилласан байна.</p> <p>Мөн баруун бүсийн аймгуудын цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хоол зүйч, тогооч нарын дунд "Малын дотор мах, дайвар түүхий эд ашиглан, хүүхдийн хоолны шинэлэг жор, технологи боловсруулах" 13.5 сая төгрөгийн шагналын сантай уралдааны 1-р үе шатыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Боловсрол соёлын газартай хамтран зохион байгуулж, баруун бүсийн аймгуудын нийт 112 хоол зүйч, тогооч оролцсон.</p>	100

				<p>Хоол үйлдвэрлэл үйлчилгээ бүхий газрын хоолны цэсэд сультай цай, борви тойгтой хоол, цай, арвай, сультай боорцог зэргийг нэмэлтээр оруулсан.</p>	
6.5	<p>Нийтийн хоолны газар, зочид буудал, зоогийн газар, бар ресторонуудад үйлчилгээний стандартыг мөрдүүлж, хоол үйлчилгээний чанар, үйлчлэгч зөөгч, ресепшний мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор МУИС-ын харьяа Бизнесийн их сургуулийн зочид буудал, зоогийн газрын чиглэлээр мэргэшсэн арга зүйч, сургагч багш Б.Долгортой хамтарч 2025 оны 4 дүгээр сард сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд хугацаа хүлээгдэж байгаа болно.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>		<p>Аймгийн Хантайшир тогоочдын холбоотой хамтран нийтийн хоолны газар, зочид буудал, зоогийн газар, бар ресторонуудад үйлчилгээний стандартыг мөрдүүлж, хоол үйлчилгээний чанар, үйлчлэгч зөөгч, ресепшний мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор МУИС-ын харьяа Бизнесийн их сургуулийн зочид буудал, зоогийн газрын чиглэлээр мэргэшсэн арга зүйч, сургагч багш Б.Долгортой хамтарч 2025 оны 4 дүгээр сард сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд хугацаа хүлээгдэж байгаа болно.</p>	50
Зорилт 7. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжин бизнес эрхлэгчдийг төсөл, хөтөлбөрт хамруулж, хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ.					
7.1	<p>Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжих</p>	<p>Хөнгөлөлттэй зээл, дэмжлэгт хамрагдсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоо</p>	<p>18 аж ахуйн нэгж, 29 иргэнд 1,615.6 сая төгрөг</p>	<p>Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд хамрагдах нийт 17 аж ахуйн нэгжийн 2,796.5 сая төгрөгийн зээлийн хүсэлтийг sme.gov.mn цахим сайтаар хүлээн авч 4 шатны үнэлгээгээр сонгон шалгаруулж, 10 аж ахуйн нэгжийн 1,100.0 сая төгрөгийн зээлийг олгоод байна. Аймгийн ЖДҮХС-аас Бугат сумын иргэнд гэр буудал, зоогийн газар байгуулах зориулалтаар 50,0 сая төгрөг, Цогт сумын Баянтоорой тосгоны иргэнд жуулчны баазын зориулалтаар 65,0 сая төгрөг нийт 115,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олголоо.</p>	100
7.2	<p>Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүү, хүний нөөц, маркетинг, хууль зүй болон бусад чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлж сургалт зохион байгуулах</p>	<p>Зохион байгуулсан сургалтын тоо</p>	<p>17 удаагийн сургалтанд нийт 276 иргэнийг хамруулсан.</p>	<p>Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээл олгохтой холбогдох мэдээ мэдээлэл өгөх сургалтыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт 2 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулж, сургалтад 15 хүн хамрагдсан. Зээлтэй холбоотой ганцаарчилсан зөвлөгөөг давхардсан тоогоор 105 иргэнд өгсөн.</p>	100
7.3	<p>Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр үзэсгэлэн, форум, телевизийн нэвтрүүлэг, уулзалт зохион байгуулах</p>	<p>Зохион байгуулсан арга хэмжээний тоо</p>	<p>4 удаагийн үзэсгэлэн худалдаанд оролцсон.</p>	<p>"Цагаан сар-2024" үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, цагаан идээ, хэвийн боов, гар урлал, үндэсний хувцас зэрэг 16 нэр төрлийн бүтээгдэхүүнээр 50 гаруй өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид оролцож 220,0 сая төгрөгийн борлуулалт хийлээ. "Хантайшир экспо-Ургацын баяр 2024", "Үржлийн шилмэл мал-2024" үзэсгэлэн дуудлага худалдааг 9 дүгээр сарын 21,22-ны өдрүүдэд Алтай хотод зохион байгуулж, 18 сум,</p>	100

				<p>2 тосгон, Завхан аймгийн 140 гагц хоршоо, бүлэг, нөхөрлөл, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид үндэсний хувцас, гутал, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, сүү цагаан идээ, гар урлал, нийтийн хоол зэрэг 90 гаруй нэр төрлийн, бүтээгдэхүүнийг үзүүлэн сурталчилж, 125,0 гаруй сая төгрөгийн борлуулалт хийлээ.</p>	
7.4	<p>Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн үйл ажиллагааг сайжруулж, зээлдэгчийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд нэгтгэх ажлыг зохион байгуулах</p>	<p>Чанаргүй зээлийн хэмжээ хувьвар</p>	<p>Чанаргүй зээлийн хэмжээ 27 хувь байна.</p>	<p>Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээг бууруулах зорилгоор Говь-Алтай аймаг дахь Төрийн Аудитын газар, Шүүх, Прокурорын байгууллагатай хамтран ажиллаж байна. Тайлант онд нийт 913.1 сая төгрөгийг санд төвлөрүүлж 16 зээлдэгчийг хуулийн байгууллагад шилжүүллээ. Хугацаа хэтэрсэн зээлдэгчдийн мэдээллийн аймгийн Прокурорын газарт хүргүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.</p> <p>Тус сангаас зээл авсан зээлдэгчдийн мэдээллийг сумдын вэб сайт, мэдээллийн самбарт байршуулан мэдээллийг ил тодоор иргэд хүргэж байна. Сангийн зээлдэгчдийн мэдээллийг сар бүр Монгол банкны Зээлийн мэдээллийн санд илгээж байна. Зээлийг бүрэн төлж барагдуулсан болон зээлийн ангилал буурсан засуулах хүсэлт ирүүлсэн иргэдийн мэдээллийг тухай бүрд нь шийдвэрлэж, Зээлийн мэдээллийн санд илгээж мэдээллийг шинэчлэн ажилласан.</p>	100
Зорилт 8. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг бүсчлэн хөгжүүлж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ.					
8.1	<p>Сум бүрт загвар хоршоо байгуулах</p>	<p>Байгуулагдсан хоршооны тоо</p>	<p>4 загвар хоршоо байгаа болно.</p>	<p>Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд Хөхморьт сумын "Сулин дэнж" хоршооны материалыг тэргүүний хоршоогоор шалгаруулахаар тодорхойлж ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Тогтвортой ноос, ноолуур эвсэл, "Нутгийн үйлс" сургалт судалгааны төвтэй хамтран "Мал аж ахуй эрхлэх ноолуур бэлтгэх зохистой дадал", "Ноолуур ангилан бэлтгэгч" сургалтыг зохион байгуулж Баян-Уул сумын "Санжинбогд", Дэлгэр сумын "Хөв дэлгэр" хоршооны 28 малчид, гишүүдийг хамрууллаа. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд шинээр байгуулагдсан хоршоодод зөвлөн туслах, тогтвортой байдлыг хангах, хоршооны түүхий эд борлуулалт болон бүтээгдэхүүн хөгжүүлэлт,</p>	100

				<p>эртний сүлжээнд тулгарч буй асуудлыг тодорхойлж, дэмжлэг үзүүлэх зорилгоор "Хоршооны дарга, гишүүдийг чөдавхжуулах" сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 18 сумын сумдын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, хоршооны дарга, гишүүн нийт 200 хүн хамрагдлаа. Загвар хоршооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор Хөхморьт сумын "Сулэн дэнж" хоршооны "Ноос боловсруулах" үйлдвэрийн төслийг дэмжиж ЖДҮХСангаас 195.0 сая төгрөгийн зээлийг олголоо. Мөн тус хоршоо нь Улсын тэргүүний хоршоогоор шалгарч 10.0 сая төгрөгөөр шагнагдсан.</p>	100
8.2	<p>Малчид, малчдын хоршоодод зориулсан түүхий эд бэлтгэлийн чиглэлээр шаталсан сургалтыг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах</p>	<p>Сургалтад хамрагдсан малчид хоршоологчдын тоо</p>	<p>2 удаагийн сургалтад 69 хоршоологчид, малчид холбогдох албан тушаалтнууд хамрагдсан.</p>	<p>Малчид, малчдын хоршоодод зориулсан түүхий эд бэлтгэлийн чиглэлээр шаталсан сургалтыг зохион байгуулахаар "Ирвэстэй нутгийн ирээдүй" төслийн 2024 оны ажлын төлөвлөгөөнд тусгуулсан бөгөөд бусад төсөл хөтөлбөртэй хамтран хоршоологчдын сургалтыг зохион байгуулахаар ажиллаж байгаа болно. Тогтвортой ноос, ноолуур эвсэл, Нутгийн үйлс сургалт судалгааны төвтэй хамтран "Мал аж ахуй эрхлэх ноолуур бэлтгэх зохистой дадал", "Ноолуур ангилан бэлтгэгч" сургалтыг зохион байгуулж, Баян-Уул сумын "Санжинбогд", Дэлгэр сумын "Хөв дэлгэр" хоршооны нийт 28 малчин хамрагдлаа.</p>	100
8.3	<p>Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх хувийн хэвшлийг дэмжиж ажиллах</p>	<p>Мах болон сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийг бодлогоор дэмжиж ажиллана.</p>	<p>МХЭСХ-өөр 8 иргэнд 190,0 төгрөгийн зээл олгосон</p>	<p>Аймгийн мал эргэлтийн сангийн хөрөнгөөс тайлант онд зээл олгодоогүй ба өмнөх оны зээлийн эргэн төлөлтийг харгалаан үзэж дараагийн зээлийг олгох ажлыг хэлэлцэхээр хүлээгдэж байгаатай холбоотой зээл олгогдоогүй байна. Мөн "Шинэ хоршоо чинээлэг малчин" үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 500 хоршоо бүртгэгдсэнээс 219 хоршоонд Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр зээл олгогдсон байна.</p>	100
Зорилт 9. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг бодлогоор дэмжин, үйл ажиллагааг сайжруулж ажлын байрыг нэмэгдүүлнэ.					
9.1	<p>Төвөөс алслагдсан сум, багт явуулын ахуйн үйлчилгээг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах</p>	<p>Ахуйн үйлчилгээ үзүүлсэн сумын тоо</p>	<p>18 сумын 88 багийн хэмжээнд 598 иргэнд хүрч үйлчилсэн.</p>	<p>Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, төсөл хөтөлбөрт иргэдийн санал санаачилгыг сонсож тусгах, төрийн үйлчилгээг хөдөөгийн малчид, иргэдэд хүргэх ажлын хүрээнд явуулын ахуй</p>	100

9.2	Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах	Зээлд хамрагдсан ахуй үйлчилгээ эрхлэгчдийн тоо	XXC-аас 12 иргэн, 1 аж ахуйн нэгжид 128.8 сая төгрөгийн зээл олгож, 12 ажлын байр шинээр, ХЗДС-аас 35 иргэнд 213.0 сая төгрөгийн зээл олгож, 20 ажлын байр шинээр бий болсон байна.	Үйлчилгээг малчдад хүргэх ажлыг 5 сая 250 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.	зохион байгуулж 100
-----	--	---	---	--	------------------------

Зорилт 10. Мал эмнэлгийн чиглэлээр

10.1	Адууны ям, үхрийн сүрьеэ, бог малын мялзан, шүлхий өвчний тандах шинжилгээ хийх	Цуглуулсан дээжийн тоо	2000 дээж цуглуулан шинжилгээ хийсэн.	Гоц халдварт 4 өвчний тандах шинжилгээнд 480 дээжид шүлхий, бог малын мялзан, Үхрийн сүрьеэ өвчний харшил сорилын шинжилгээг Есенбулаг, Дарив сумын Рашаант, Жавхлант, Үйлдвэр, Ихэс, Хужирт багийн 600 үхэрт, Адууны ям өвчний шинжилгээг Есенбулаг, Дарив сумын Рашаант, Жавхлант, Үйлдвэр, Ихэс, Хужирт багийн 600 адуу бүхий нийт 1680 толгой малыг хамруулж, шинжилгээгээр өвчний үүсгэгч илрээгүй. Мөн Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагаас баруун бүс нутгийг шүлхийгээр тайван, вакцин хэрэглэдэггүй статус авах зорилгоор УМЭАЦТЛ-н гэрээ, удирдамжийн дагуу 15 сумдын 30 багийн 64 айл өрхөөс Үхэр-256, Хонь-384, Ямаа-384 нийт 1024 толгой малаас ийдэсний дээж цуглуулан шүлхий өвчний бүтцийн бус уураг илрүүлэх ELISA урвалын шинжилгээ хийсэн. Шинжилгээгээр эерэг урвалтай дээж илрээгүй болно.	100
10.2	Мал сүргийн дархлаажуулалт, эмчлэн сэргийлэх ажлыг лабораторийн түүвэр шинжилгээгээр тогтоох	Дархлаажуулалта д хамрагдсан малын тоо	14000 дээжид түүвэр шинжилгээ хийгдсэн	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн захирал, Говь-Алтай аймгийн Мал эмнэлгийн газрын даргатай байгуулсан гэрээний дагуу 2024 онд 7472 ухна,	100

				<p>5186 хуц, 246 буур, 1136 бух нийт-1420 хээлтүүлэгчийн ийлдсэнд бруцеллэз өвчнийг илрүүлэх розбенгалын шинжилгээ хийж өвчний үүсгэгч илрээгүй.</p> <p>Шүтхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 2024 оны хаврын вакцинжуулалтын дараа Шүтхийн вакцины дархлааны идэвх шалгах О ба А хэвшлийн SPCE-ЕЛИЗА урвалын шинжилгээг 18 сумын 54 малчин өрхийн нийт 180 ширхэг үхрийн ийлдэсний дээжийг цуглуулан Мал эмнэлгийн төв лабораторид хүргүүлээ. Одоогоор шинжилгээний хариу ирээгүй байна.</p>	
10.3	Мал угаалгын ванныг шинэ стандартын дагуу баг сумдад барих ажлыг идэвхжүүлэх	Ашиглалтад орсон ванны тоо	7 сумд мал угаалгын ванн болон Дук машин нийлүүлэн ашиглалтад оруулсан	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Эрдэнэ 1 мал угаалгын ванн, Халиун сумд мал угаалгын шүршдэг тоног төхөөрөмжийг нийлүүлэн хүлээлгэн өгсөн. Мөн Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 145.0 сая төгрөгийн хөрөнгөөр Бигэр, Тонхил, Жаргалан сумдад мал угаалгын ДУК машин, Эрдэнэ сумд 39.3 сая төгрөгөөр мал угаалгын 2 ванныг барьж ашиглалтад оруулаад байна.	100
10.4	Халдварт, паразиттах өвчний голомт судалгаанд үндэслэн малыг эрүүлжүүлэх	Хамрагдсан малын тоо	2551.3 мянган мал хамруулсан	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/68 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/197 дугаар захирамж, Мал эмнэлгийн газрын даргын А/11 дүгээр тушаалын дагуу "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1226.7 мянган мал хамруулахаас 1222.7 мянган мал хамрагдаж, дархлаажуулалт 99.7 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж дууссан. Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 1418.7 мянган мал хамрагдахаар төлөвлөгдөж 1354.6 мянган мал хамрагдаж мал эмнэлгийн нэгдсэн системд гүйцэтгэл орж баталгаажигдлаа.	100
10.5	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг сайжруулж, хяналт тавих хорио цээрийн хяналтын цэгийг байгуулах	Хамрагдсан сумын тоо	4 сум	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар мал эмнэлгийн ерөнхий газар орон нутагт хяналтын цэг байгуулах нэгдсэн зураг төсөв боловсруулах, мэргэжлийн ажиллах хүчний цалин хөлс бусад холбогдох зардлыг нэгдсэн байдлаар тооцоолон, ХХААХУЯ болон Засгийн газрын түвшинд хэлэлцэж шийдвэрлэхээр болсон тул энэ ажил орон нутгийн түвшинд хийгдээгүй болно.	ҮБ
10.6	Малын гоц болон халдварт өвчингүй эрүүл бүс нутаг болох хөдөлгөөн өрнүүлэх	Гүйцэтгэлийн хувь	-	Малын гоц болон халдварт өвчингүй эрүүл бүс нутаг болох хөдөлгөөний хүрээнд улсын хэмжээнд нэгдсэн байдлаар шүлхий, бог малын мялзан, хонины цацаг өвчин зэрэг гоц халварт өвчний тархалтыг илрүүлэх, дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах, эрт	100

					илрүүлгийн үзэлийг орон нутагтаа цаг тухай бүрт хэрэгжүүлэн ажиллаж байна.	
Зорилт 11 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, хортон мэрэгчтэй тэмцэж, ашиглалтыг сайжруулна.						
11.1	Бэлчээрт хөнөөл учруулж буй хортон мэрэгчтэй дөвшилтэд техник технологийг ашиглан тэмцэх арга хэмжээг зохион байгуулах	Үлийн цагаан оготнотой тэмцэх талбайн хэмжээ	47.5 мянган га талбайд тэмцэх ажлыг зохион байгуулсан		"Хан-Алтай ресурс" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд Есөнбулаг сумын Рашаант, Наран багийн нийт 3.8 мянган га талбайд механик аргаар үлийн цагаан оготно болон царцаатай тэмцэх 800 ш шувууны суулт, 200 ш шувууны үүрийг 20.0 сая төгрөгийн төсөвт өртөөр хийж гүйцэтгэсэн.	50
11.2	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд бэлчээрт гүн өрмийн болон энгийн уурхайн худаг шинээр гаргах, сэргээн засварлах арга хэмжээг зохион байгуулах	Шинээр гаргасан болон сэргээн засварласан худгийн тоо	7 сумд гүн өрмийн худаг шинээр гаргасан.		Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 697,6 сая төгрөгийн санхүүжилтээр 6 сумд 10 худаг, Туркийн хамтын ажиллагааны зохицуулах агентлаг ТИКА төслийн 226,0 сая төгрөгийн санхүүжилтээр Бигэр, Хөхморьт, Цогт, Чандмань, Эрдэнэ сумдад, Улсын төсвийн 395,8 сая төгрөгийн хөрөнгөөр Цогт, Эрдэнэ, Чандмань, Халуун, Цээл сумдад 11 инженерийн хийцтэй гүн өрмийн худгийг шинээр гарган ашиглалтад оруулсан.	100
Зорилт 12 Мал сүргийн эрсдлийг бууруулах, даатгалд хамруулах арга хэмжээг зохион байгуулна.						
12.1	Мал сүргийг малын индексжүүлсэн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах	Даатгалд хамрагдсан малчин өрх, малын тоо	Нийт малчин өрхийн 25 хувь, мал сүргийн 13 хувь хамрагдсан		18 сумын 2007 малчин өрхийн 501,2 мянган толгой мал буюу нийт мал сүргийн 16,6 хувь нь малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан байна	100
12.2	Засгийн газрын тогтоолын хүрээнд аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	Аймгийн аюулгүй нөөцөд бэлтгэсэн өвс, тэжээлийн хэмжээ	Өвс 200 тн, тэжээл 50 тн		2024 оны 28 дугаар тогтоолоор аймаг аюулгүйн нөөцөд 200 тн өвс, 50 тн тэжээл, сумууд 50 тн өвс, 30 тн тэжээл бэлтгэхээс аймгийн аюулгүйн нөөцийн 300 тн өвсийг ОНТ-ийн 210,0 сая төгрөгийн санхүүжилтээр "Тэргүүн хийц" ХХК, 50 тн тэжээлийг ОНТ-ийн 50,0 сая төгрөгийн санхүүжилтээр "Улаан цахир" ХХК-тай тус тус гэрээ байгуулан нийлүүлэгдээд байна. Сумдын аюулгүйн нөөцөд 640.9 тн өвс, 371.1 тн тэжээл бэлтгээд байна.	100
Зорилт 13 Тайшир-Есөнбулаг чиглэлийн 35 кВ-ын ЦДАШ-ыг 110 кВ болгон өргөтгөж, аймгийн төв болон сумдын цахилгаан эрчим хүчний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.						
13.1	Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв хүртэлх 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг 110 кВ болгон өргөтгөх ажлын хэрэгжилтийг хангуулах	Хэрэгжилтийн хувиар	30%		Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв хүртэлх 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг 110 кВ болгон өргөтгөх ажлын гүйцэтгэгчээр "ДМТМ" ХХК шалгаран гэрээ байгуулан техникийн комисс ажиллалаа.	90

13.2	Алтай сумын 35 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам ажлыг эхлүүлэх	Гүйцэтгэлийн хувиар	30%	Алтай сумын 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, сумын төвд 35/10кВ, 1000кВА-ын дэд станц, 10/0,4кВ-ын 4 ширхэг дэд станц, 0,4 кВ-ын ЦДАШ-ын шинэчлэл шинээр баригдаж БНХАУ-ын импортын эрчим хүчний системд холбогдлоо.	100
13.3	Дарив сумын нэгдсэн халаалт, цэвэр бохир, усны шугамын зураг төсөв боловсруулах	Гүйцэтгэлийн хувь	-	Дарив сумын нэгдсэн халаалт, цэвэр бохир, усны шугамын зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэгчээр "Мөнх консалтинг" ХХК шалгаран байнгын ашиглалтад орууллаа.	100
13.4	Алтай хотод баригдах 25 мВТ-ын хүчин чадалтай дулааны станц, дулаан дамжуулах төвийн барих ажлыг үргэлжлүүлэх	Гүйцэтгэлийн хувь	30%	25 МВт хүчин чадалтай дулааны станц барих ажлыг БНСУ-ын Экспорт-Импорт банкны санхүүжилтээр "Бюксан инженеринг" ХХК гүйцэтгэхээр шалгарсан бөгөөд зураг төслийн ажил болон барилга угсралтын ажлыг хамтад нь гүйцэтгэж байна. Зураг төслийн ажлын туслан гүйцэтгэгчээр "Мон энержи" ХХК ажиллаж байгаа бөгөөд 2022 онд Дулааны станцын хашаа, станцын суурийн ажлыг хийж гүйцэтгэсэн бол 2023 онд барилга угсралтын ажил эхэлж зуухны угсралтын ажил 90%-тай, барилгын суурийн ажил 80%-тай, үндсэн барилгын керказ угсрах ажил хийгдэж байна	70
13.5	Халиун сумын цэвэрлэх байгууламжийг гадна цахилгаан хангамжид холбох	Гүйцэтгэлийн хувь	-	Халиун сумын цэвэрлэх байгууламжийг гадна цахилгаан хангамжид холбох ажлын гүйцэтгэгчээр "Жаргалант ургамал" ХХК шалгаран байнгын ашиглалтад орууллаа.	100
13.6	Бигэр сумын төвийн инженерийн шугам сүлжээний нэгдсэн систем, уурын зуухны барилгын ажлыг үргэлжлүүлэх	Гүйцэтгэлийн хувь	30%	Бигэр сумын төвийн инженерийн шугам сүлжээний холболт, уурын зуухны барилгын ажлыг улсын төсвийн 2,493.8 сая төгрөгийн хөрөнгөөр "Сити агро эх" ХХК гүйцэтгэж, ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна. Мөн Бигэр сумын хуучин халуун уснаас 120 айлын ЦТП хүртэлх 310м дулаан, цэвэр усны шугам сүлжээний ажлыг төр, хувийн хэвшлийн Түншлэлийн хүрээнд "Говийн гал голомт" ХХК-тай гэрээ байгуулан байнгын ашиглалтад оруулах комисс ажиллахаар хүлээгдэж байна.	100
13.7 46	Шарга, Хөхморьт сумдад цахилгаан түгээх сүлжээний шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлнэ.	Ажлын гүйцэтгэлээр	-	Дэлхийн банкны санхүүжилтээр "Эрчим хүчний төсөл-2"-ийн хүрээнд Шарга, Хөхморьт сумдад цахилгаан түгээх сүлжээний шинэчлэлийн ажил бүрэн хэрэгжиж хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.	100
Зорилт 13 Хүн амын усан хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуулын ажлыг хийж, нөөцийг тогтоон, бохирдож, хомсдохоос сэргийлж, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэн ундны усны чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангах бодлогыг олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ					

13.1	Гадаргын усыг нэмэгдүүлэх зорилгоор булаг шандны эхийг хашиж хамгаалах, тохижуулах, картжуулах ажлыг эрчимжүүлэх	Хашиж хамгаалсан булгийн тоо	21	БХНСАХ зардал 60,100.0 төгрөгөөр Эсенбулаг, Алтай, Дэлгэр, Тайшир сумд нэг нийт 4 булгийн эхийг хашиж хамгаалах ажлын гүйцэтгэлээр "Жаргалан хүлэмж" ХХК шалгарч гэрээ байгуулж урьдчилгаа санхүүжилт 40 хувийг олгож бараа материалаа татан авч бэлдцээ бэлтгэж байна. Мөн ENSUR төсөл Эрдэнэ сумд 1, ДБХ сангийн санхүүжилтээр 7 сумын 18 булаг хамгаалах бараа материал нийлүүлж сум орон нутаг бэлдэц бэлтгэх, газар дээр нь байршуулах ажлыг хариуцан зохион байгуулж 3 сумын 10 булаг хамгаалах ажил бүрэн хийгдлээ. Дээрх булаг хашиж хамгаалах ажлуудыг аймгийн Засаг даргын 2023 оны А/72 дугаар захирамжаар баталсан "Булаг хамгаалах аргачлал заавар"-т тусгагдсаны дагуу чанартай хийгдэж байна.	100
13.2	Зэрлэг амьтны усан хангамжийг сайжруулах зорилгоор цас борооны ус хуримтлуулах хөв байгуулах засварлах	Байгуулсан хөвийн тоо	-	Чандмань сумын "Ширээгийн ус" нэртэй газарт 8370 м <sup>3</sup> цас борооны ус хуримтлуулах хөв цөөрмийг ENSURE төслөөс 44.9 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгүүлж ашиглалтад хүлээн авч орон нутгийн өмч хөрөнгөнд бүртгүүлж, цаашдын ашиглалт хамгаалалтыг сум хариуцахаар боллоо. Эрдэнэ сумын Хөтөл усанд Unitel group-тэй хамтран зэрлэг амьтанд зориулсан 1м <sup>3</sup> багтаамжтай жижиг хөв байгуулан ашиглалтад орууллаа. Ингэснээр тус аймагт 2 хөв цөөрөм байгуулагдлаа. Мөн Бөхөн бүхий 7 сумдад хашиж хамгаалсан булгийн урсгал дагуу 6 байршилд жижиг хөв цөөрөм байгуулахаар БХНСАХ зардал 20.0 сая төгрөгийг нэмж тодотгуулан "Энгүүн Нуур" ХХК – тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлээ. Уг 6 хөв цөөрөм байгуулах ажил хийгдсэнээр нийтдээ 24м <sup>3</sup> ус хуримтлагдаж зэрлэг амьтан, бэлчээрийн усан хангамж сайжирна.	100
13.3	Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоож, тэмдэгжүүлэлтийн самбар байршуулан дэглэмийг мөрдүүлэх	Хамгаалалтын бүс тогтоосон ол, нуурын, самбарын тоо	6 усны эх үүсвэр 18 ширхэг самбар	Халиун сумын "Халиун" гол, Цээл сумын "Усана эх"-ийн рашаан зэрэг 2 усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоож 1,25 га талбай хамгаалагдаж, явган зам, сүүдрэвч хийж тохижуулан нөлөөлөлд өртдөг 4 газарт тэмдэгжүүлэлт хийж дэглэмийг мөрдүүлээ. Тус ажилд БХНСАХ зардал 24.0 сая төгрөг, ОНТ төсөв 10.0 сая, Төсөл хөтөлбөрийн санхүүжилт 56.0 сая нийт- 90.0 сая төгрөг зарцуулагдлаа. Мөн Эсенбулаг сумын Шаврын голын усны сан бүхий газрын эх бүрдэх хэсэгт тэмдэгжүүлэлтийн 2 самбар хийж байршуулан дэглэмийг мөрдүүлээ.	100

13.4	Сэргээгдэх эрчим хүч ашиглах зорилгоор нарны өргүүртэй гүн өрмийн худаг гаргах	Хүдгийн тоо	Зэрлэг амьтны усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Цогт сумын Идрэнгийн нуруунд нарны хөргүүртэй гүн өрмийн 1 худгийг ENSURE төслийн санхүүжилт 120.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэн хүлээн авч ашиглалтад орууллаа. Мөн ГИДЦГ-ын "А" хэсгийн хамгаалалтын захиргаа нэн ховор, ховор амьтдын байршил нутагт байгаа гэр худгийг сэргээн засварлан нарны өргүүртэй автомат төхөөрөмж суурилуулан ашиглалтад орууллаа. Тус ажилд нийт 35.0 сая төгрөг зарцуулагдсан байна.	100
Зориолт 14 Хөрсний үржил шим, чийгийг ойн зурвас, хөв цөөрөм байгуулах, булаг шандны эхийг хаших замаар хамгаалж, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх.				
14.1	Жуулчны бааз, амралт, сувиллын газруудын ариун цэврийн байгууламжийг стандарт шаардлагад нийцүүлэн шинэчлэх	Шинэчилсэн ариун цэврийн байгууламжийн тоо, стандартын шаардлага хангасан 00-н тоо	Ариун цэврийн байгууламж 1, стандартын шаардлага хангасан 00-н тоо-3	100
14.2	"108 сая мод тарьж, ургуулах аян"-ыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, хавар намрын мод тарих аяныг өрнүүлэх	Тариалсан суугацын тоо	Аймгийн хэмжээнд хавар, намрын бүх нийтээр мод тарих аяны хүрээнд 05, 10 дугаар саруудад 9-н төрлийн гоёлын болон жимс жимсгэний тарьц суулгацын үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Тус үзэсгэлэн худалдаагаар айл өрх, аж ахуйн нэгж, албан байгууллагад шаардлагатай тарьц суулгацыг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж аймгийн хэмжээнд нийт 140 гаруй аж ахуйн нэгж, албан байгууллага, 4212 иргэн оролцож 13 төрлийн 101198 ширхэг мод бут сөөг тарьж, 3 га талбайн хайс хамгаалалт, услалтын системүүдийг засаж сэлбэн мод тариалалтын ажилд 139.2 сая төгрөг зарцуулсан.	100

14.3	Хууль бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон газрын нөхөн сэргээлтийг хийлгэн хүлээн авах	Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ /га/	30 га	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дагуу Цогт эрин транс ХХК нь 2021-2022 онд олборлолтын үйл ажилгаа явуулахдаа эвдрэлд оруулсан 23.26 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийн хүлээлгэн өгсөн. Нөхөн сэргээлтийн ажилд нийт 770 сая төгрөгийг зарцуулсан байна. Хууль бусаар ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас Тайшир, Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт эвдрэлд орж орхигдсон 13.8 га талбайг ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй "Хан Алтай ресурс", "Болд гянт болд" ХХК-ууд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд, Орон нутгийн төсөв болох байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 8.41 га талбайг, нийгмийн хариуцлагын хүрээнд төрийн бус байгууллагуудаар 7.98 га талбайг нийт 30.19 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг Орон нутгийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар стандартын дагуу хийлгэн хүлээн авч 154 сая төгрөгийг зарцуулан ажиллалаа.	100
Зорилт 15 Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах чиглэлээр					
15.1	Цогт сумын орон нутгийн тусгай хамгаалалттай газар болох Гичгэнэ Уул, Баянтооройн бүрдийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах	Батлагдсан менежментийн төлөвлөгөө	1	Цогт сумын орон нутгийн тусгай хамгаалалттай газар болох Гичгэнэ уул, Баянтооройн бүрдийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлын гүйцэтгэлээр "ТХГНутгийн судалгааны төв ТББ" шалгаран гэрээ байгуулан ажлыг эхлүүлээ. Менежментийн төлөвлөгөө боловсруулах ажил нь Elsure төслийн 50.5 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдэж байна.	50
15.2	Улсын тусгай хамгаалалттай газар нутагт амьдардаг малчин өрхтэй газар ашиглах гурвалсан гэрээ байгуулах.	Гэрээ байгуулсан малчин өрхийн тоо	232 өрх	Хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын төлөвлөгөөнд туссан ажлын хүрээнд өвөлжилт, хаваржилт хүндэрсэн үеэр ГИДЦГ-ын "А" хэсгийн хамгаалалттай газар нутагт 500000 га талбайд 150 өрх, 15000 орчим малыг 12 дугаар сараас 02 дугаар сарын 20-ныг хүртэл, ГИДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалттай газар нутагт 450000 га талбайд 125 өрх, 12000 орчим малыг 12 дугаар сараас 03 дугаар сарын 10-ныг хүртэл хугацаанд өвөлжүүлж хаваржуулах боломжит судалгааг гаргалаа. Улсын тусгай хамгаалалттай бус нутагт 7 сумын 322 малчин өрхийн 164.3 мянга, Хилийн зурваст 2 сумын 109 өрхийн 48.7 мянга, өөр аймгийн нутагт 5 сумын 19 өрхийн 7.2 мянга, өөрийн аймгийн бусад сумын нутагт 9 сумын 56 өрхийн 29.7 мянга бүхий нийт 549 малчин өрхийн 274.3	100

	мянган толгой мал отроор өвөлжиж, хэрэгжих урьдчилсан судалгаа гараад байна.					
Зорилт 16	Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.					
16.1	Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг аймгийн нийт малчин ерхийн гар утсанд нь мессежээр "Багц мэдээ" хүргэж ажиллах. E-office программмын мэдээллийн хэсэгт байршуулан аймгийн төрийн байгууллагуудад мэдээлэх.	"Багц мэдээ" дамжуулсан тоо	31 удаа,			Сумдын болон албан байгууллагуудын зарын групп, хаягуудаар урьдчилсан мэдээг дамжуулж байна.Цаг агаарын аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлж нөхцөл бүрдсэн үед багц мессежээр малчид, тээвэрчид, ард иргэдэд хугацаа алдалгүй хүргэх ажлыг аймгийн хэмжээнд хийт 6000 малчин ерхийн гар утсанд мессеж мэдээлэл түгээж хэвшсэн. Багц мессежийн давхардсан тоогоор 350000 хэрэглэгчид дамжуулан ажилласан байна. Нэг удаа 5660 хүнд малчин өрхөд 18 сум 2 тосгоны хэмжээнд Юнител-ийн дараа төлбөрт үйлчилгээгээр багц мессежийг хурдан шуурхай хүргэж байна.Мөн Анхааруулга ,Сэрэмжлүүлэг мэдээг Говь-Алтай Ус Цаг Уур фасебоок хаяг болон аймгийн төрийн байгууллагуудад мэдээлэн ажиллаж байна.
16.2	Агаар бохирдуулах эх үүсвэрийн тооллого хийх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах	Тооллого хийгдсэн байна.	1			Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг аймгийн Засаг даргын 2023 оны А/624 дугаар захирамжийн дагуу төлөвлөгөө боловсруулан 18 сум 2 тосгоны хүрээнд зохион байгуулсан. Бүх сумдад ажлын хэсэг байгуулж сумдын цаг уурын өртөө нарт мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч цахим програмд оруулсан. Нэгдсэн тайлан мэдээг холбогдох газруудад хүргүүлсэн.
Зорилт 17 Орон нутгийн чанартай авто зам, гүүрийн байгууламжийн засвар арчлалтыг гүйцэтгэнэ.						
17.1	Ентүм зочид буудлаас 3.4 дүгээр байрны хойд талын уулаар хүртэлх зам, Хийдийн 60 автомашины зогсоол, Жинст баг Хөгжил хорооллын доод талаас 3, 4 дүгээр хорооллын доод талаас 3, 4 дүгээр хорооллын гудамжны хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулах	Гүйцэтгэлийн хувь	10%			Ентүм зочид буудлаас 3, 4 дүгээр байрны хойд талын уулаар хүртэлх авто зам, Хийдийн 60 авто машины зогсоол, Жинст баг, Хөгжил хорооллын доод талаас 3, 4 дүгээр гудамжны хатуу хучилттай авто замын ажлын гүйцэтгэгч "Сакод импорт" ХХК шалгаран гэрээ байгуулан хөдөлгөөс хамгаалах үе шатны ажил хийгдэн материал татан авалт хийгдлээ.
17.2	Аймгийн төвийн 10 км авто замыг барих ажлыг үргэлжлүүлэх	Гүйцэтгэлийн хувь	-			Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй Аймгийн төвийн 10 км хатуу хучилттай авто замын ажлыг 9,964.3 сая төгрөгөөр "Түм дэлгэрэх" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд тайлант үеийн байдлаар 4.3 км замын хучилт хийгдсэн.

17.3	Аймгийн төвийн 15,6 км хатуу хувийттай авто зам тавих ажлыг эхлүүлэх	Ажлын гүйцэтгэлээр		Аймгийн төвд шинээр 15,6 км хатуу хувийттай авто замыг барих ажлын гүйцэтгэлээр "Бумбат даваа" ХХК шалгаран гэрээ байгууллаа. Зорчигч тээврийн авто үйлчилгээний төвийн барилгын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар зарласан бөгөөд гүйцэтгэгчээр "Мөрөн-Алтай" ХХК шалгарч, 3,244.7 сая төгрөгөөр түлхүүр гэрдуулах нөхцөлтэй ажил гүйцэтгэх гэрээг Зам, тээврийн хөгжлийн яаманд байгуулсан. Тайлант үеийн байдлаар барилгажих талбайн инженер геологийн дүгнэлт хийгдэж, зураг төсөл боловсруулах ажиллагаа хийгдэж байгаа бөгөөд зөвшөөрөгдсөн газрын байршил өөрчлөгдсөн тул барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгогдоогүй байна.	50
17.4	Зорчигч тээврийн авто үйлчилгээний төвийн барилгын ажлыг эхлүүлэх	Ажлын гүйцэтгэлээр		Тайлант үеийн байдлаар барилгажих талбайн инженер геологийн дүгнэлт хийгдэж, зураг төсөл боловсруулах ажиллагаа хийгдэж байгаа бөгөөд зөвшөөрөгдсөн газрын байршил өөрчлөгдсөн тул барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгогдоогүй байна.	50
Зорилт 18 "Сумдын шинэчлэл-Хөдөөгийн хөгжил" төсөл хэрэгжүүлнэ.					
18.1	Сумдад 120 айлын орон сууц барих ажлыг үргэлжлүүлнэ.	Төсөлд хамрагдсан сум-2	150 айл	Хувийн хөрөнгө оруулалтаар орон сууц барих ажлын хүрээнд эхний ээлжинд Бигэр сумд 120 айлын бүрэн цутгамал бетон орон сууцны ажлыг "Макс өргөө" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 90 хувьтай байна. Тонхил, Шарга сумдад орон сууцны барилгыг "Мөнх цамхаг" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд Тонхил сумын ажлын явц 30 хувьтай, Шарга сум гэрээ байгууллаа.	100
Зорилт 19 Сум, суурин газрын ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлж, гудамж зам талбайг хэсэгчлэн тохицуулах ажлыг эхлүүлнэ.					
19.1	"Хөгжлийн гудамж" төслийг хэрэгжүүлж, Алтай хотыг орчин үеийн хот болгох зорилтын хүрээнд Жанчивын гудамж, зам талбайг тохижуулах, авто замыг өргөтгөх шинэчлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр		Алтай хотын төв Жанчивын гудамжны авто замыг 3, 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх, хурын ус зайлуулах хоолойн инженерийн байгууламжийн ажлыг орон нутгийн 4,470.0 сая төгрөгийн санхүүжилтээр "Зэвсэгт хүчний 31 дүгээр анги"-аар гүйцэтгүүлсэн бөгөөд төслийн хүрээнд бүрэн хийгдсэн 4 эгнээ автотам, аймгийн төв талбай, ус зайлуулах хоолой, тохижилтын ажлыг хэсэгчлэн хүлээж авах улсын комисс ажиллаж, ашиглалтад орууллаа.	100
Зорилт 20 "Алсын хараа-2050" болон "Шинэ сэргэлтийн бодлого"-ын баримт бичиг, "150 мянган айл-орон сууц" үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд сум, суурин газрын дэд бүтцийг түшиглэн хямд өртөг бүхий, гадна тохижилтыг бүрэн шийдсэн стандартад нийцсэн нийтийн орон сууцны хорооллыг барьж ашиглалтад оруулж, төрийн албан хаагчдад орон сууцанд хамрагдах нөхцөлийг сайжруулна.					
20.1	"150 мянган айл-орон сууц үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд "Солонго" хорооллын дэд бүтцийг түшиглэн 1500 айлын орон сууц барьж ашиглалтад оруулах зорилтыг үе шаттай хэрэгжүүлэх	Ашиглалтад орсон орон сууцны тоо	2	Есөнбулаг сум Баянхайрхан багт 2788 айлын орон сууцны "Солонго хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн дэд бүтцийн салбар шугам сүлжээний зураг төслийн ажлыг орон нутгийн төсвийн 68.0 сая төгрөгийн хөрөнгөөр "Баяр Мега Сервис" ХХК, "Нью товер" ХХК 2022 онд гүйцэтгэж хүлээлгэн өгсөн.	100

20.2	<p>Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, орон нутгийн хариуцах санхүүжилтийг хуваарийн дагуу олгох, гүйцэтгэлд санал, зөвлөмж гаргаж ажиллана. /СЯ-ын сайд гэрээ 3.17/</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>		<p>Солонго хорооллын нутаг дэвсгэрт тайлант үеийн хугацаанд "Сабусгоби брендс" ХХК, "Мөрөн-Алтай" ХХК-УУА тус бүр 50 айлын орон сууцны барилгыг, "Босгот Толгой" ХХК 30 айлын орон сууцны барилгыг 2023 онд эхлүүлж, тайлант үеийн байдлаар 2 блок 130 айлын орон сууцны барилгыг, мөн инженерийн шугам сүлжээ бүхий газарт 4 блок 42 айлын орон сууцны барилгыг нийт тайлант хугацаанд 172 айлын орон сууцны барилгыг ашиглалтад орууллаа.</p> <p>2024 онд 5 давхар 3 блок 130 айлын орон сууцны барилгыг "Ашид гэгээн өргөө" ХХК, "Босго толгой" ХХК-ууд түншлэлээр, 9 давхар 2 блок 108 айлын орон сууцны барилгыг "Мөрөн-Алтай" ХХК тус тус гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 2025 онд нийт 238 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулахаар угсралтын ажлыг эхлүүлээ.</p> <p>Азийн хөгжлийн банкны зээлдүүлэх гэрээний нөхцөлтэй "Хот байгуулалтын салбарын МОН-2301" төсөл болон Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төслүүдийн зээлийн хүүгийн төлбөр, алдангийг орон нутаг бие даан төлөх төсвийн орлого, санхүүгийн эх үүсвэр боломжгүй 2 төсөл арга хэмжээний хүү, хүүгийн аданги, зээлийн үлдэгдэлийг Монгол Усын 2025 оны Төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар 2024.09.13-ны өдрийн 1/1135 дугаар албан бичгээр Сангийн яам, Хөгжлийн банкнд, 2024.09.27-ны өдрийн 1/1166 дугаар албан бичгээр УИХ-ын дарга Д.Амарбаясгаланд хөрөнгө шийдвэрлүүлэх хүсэлтийн хамт гэрээний хугацааг сунгах хүсэлтийг хамт хүргүүлээ.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Сангийн яам болон аймгийн Засаг даргын Тамгын газар хооронд 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан "Хот байгуулалтын салбарын МОН-2301" төслийн зээлийн гэрээний зээлийн үндсэн төлбөр, хүү, алданги болох 25,775.6 сая төгрөгийг нэр зааж тусгах замаар шийдвэрлүүлэх санал;</li> <li>2. Монгол Улсын Хөгжлийн банкны эргэн төлөгдөх "Үл хөдлөх хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах гэрээ" 2/68 дугаартай зээлийн гэрээний хүү, алданги болох 5,222.8 сая төгрөгийг Монгол Улсын төсөв болон бусад эх үүсвэрээс нэр зааж тусгуулах замаар хөрөнгө шийдвэрлэн</li> </ol>
------	--	-------------------------------------	--	---

20.3	Амины орон сууцны бүсэд иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран барилга угсралтын ажлыг эхлүүлэх	Эхлүүлсэн амины орон сууцны тоо, гүйцэтгэл	Гэрээ байгуулсан байна.	санхүүжүүлэх, мөн 2020 оны 2/68 дугаар зээлийн гэрээний хугацааг сунгаж, хүүгийн төлбөр, алдангид суутган тооцож авсан 2,451,808,021 (хоёр тэрбум дөрвөн зуун тавин нэгэн сая найман зуун наян найман мянга хорин нэг) төгрөгийг үндсэн зээлийн төлбөрт тооцуулах зэрэг асуудлыг шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээ.	0
20.4	"150 мянган айл-орон сууц үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд эрүүл мэндийн салбар, төрийн захиргааны, бусад, төрийн албан хаагчдыг орон сууцжуулах мөн түрээсийн орон сууцаар хангах, дэмжлэг үзүүлэх.	Орон сууцанд хамрагдсан албан хаагчдын тоо	Хамрагдсан ажилтны тоо-80	Эрүүл мэнд, нийгэм боловсролын салбарын, төрийн захиргааны болон бусад төрийн албан хаагч нарт орон сууцны дэмжлэг олгох ажлын хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 33 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх журам"-ыг батлуулж орон нутгийн хөгжлийн сангаас нийт 3,180.0 сая төгрөгийн санхүүжилтыг олгохоор төлөвлөвөө. Уг дэмжлэгийг олгох ажлыг зохион байгуулан хөлбодгох байгууллагуудаас материалыг хүлээн авч, хянасан байна. "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 73 дугаар тогтоолоор "Нээлттэй Алтай" арга хэмжээг батлуулан ажиллаж байгаа бөгөөд 2024 онд малчдыг дэмжих анхдугаар аяны хүрээнд "Өрх бүрт өсөлт, иргэн бүрт орлого" арга хэмжээг хэрэгжүүлэн Цогт сумын Баянтоорой тосгон, Баян-Уул, Цээл сумдын нийт 25 өрхийг малжуулан 110.0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олгосон бол Монгол Улсын Засгийн газрын "Хүнсний хувьсгал", "Шинэ хоршоо чинээлэг малчин" үндэсний хөдөлгөөний хүрээнд 18 суманд 500 гаруй хоршоо шинээр байгуулагдсан ба 360 хоршооны 1495 малчин өрхөд 49,6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг таван жилийн хугацаатайгаар олгосон байна. Үүнээс мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 32, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр 96 хоршоонд тус тус зээл олгосон байна. Мөн 2024 онд аймгийн хэмжээнд нийт 81 барилга байгууламж, бүтээн байгуулалт, инженерийн шугам сүлжээний ажил хийгдэж байгаагаас орон нутгийн төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан 15 төслийг ашиглалтад хүлээн авч, 61 төслийн барилгын ажил эхэлсэн, хэвийн үргэлжилж байна.	90
20.5	Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, хамтран ажиллах ажлын хүрээнд "Нээлттэй-Алтай" арга хэмжээг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөгөө батлагдсан.	"Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 73 дугаар тогтоолоор "Нээлттэй Алтай" арга хэмжээг батлуулан ажиллаж байгаа бөгөөд 2024 онд малчдыг дэмжих анхдугаар аяны хүрээнд "Өрх бүрт өсөлт, иргэн бүрт орлого" арга хэмжээг хэрэгжүүлэн Цогт сумын Баянтоорой тосгон, Баян-Уул, Цээл сумдын нийт 25 өрхийг малжуулан 110.0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олгосон бол Монгол Улсын Засгийн газрын "Хүнсний хувьсгал", "Шинэ хоршоо чинээлэг малчин" үндэсний хөдөлгөөний хүрээнд 18 суманд 500 гаруй хоршоо шинээр байгуулагдсан ба 360 хоршооны 1495 малчин өрхөд 49,6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг таван жилийн хугацаатайгаар олгосон байна. Үүнээс мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 32, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр 96 хоршоонд тус тус зээл олгосон байна. Мөн 2024 онд аймгийн хэмжээнд нийт 81 барилга байгууламж, бүтээн байгуулалт, инженерийн шугам сүлжээний ажил хийгдэж байгаагаас орон нутгийн төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан 15 төслийг ашиглалтад хүлээн авч, 61 төслийн барилгын ажил эхэлсэн, хэвийн үргэлжилж байна.	90

20.6	Улаанбаатар хотоос хөдөө, орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих ажлын хүрээнд шилжилт хөдөлгөөн хийсэн иргэд, аж ахуй нэгжийн судалгааг хийж, судалгааны үр дүнг нэгтгэн тайлагнаж ажиллах	Тайлагналтын тоо		Улаанбаатар хотоос хөдөө, орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих ажлын хүрээнд шилжилт хөдөлгөөн хийсэн иргэд, аж ахуйн нэгжээс судалгаа авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд хагас жилийн байдлаар Улаанбаатар хот, бусад аймгаас нийт 91 хүн шилжиж ирсэн байгаагаас, насанд хүрсэн 59, хүүхэд 32 орон нутагт суурьшсан байна. Шилжин суурьшигчидыг мэдээ мэдээллээр хангах huduu.mn платформд байршууллаа.	70
Зорилт 21	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, газар олголтыг ил тод болгоно.				
21.1	Газар өмчлүүлэх, ашиглуулах, эзэмшүүлэх үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох	Газар өмчилж авсан иргэний тоо	813	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэн газрын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгон ажиллаж байна. Мөн 2024 онд иргэдийн өөртөө үйлчлэх киоск машиныг 19.9 сая төгрөгөөр нийлүүлж, хэрэглээнд нэвтрүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээг түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлээ. Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол хийх ажлууд 2022 оноос хойш боловсруулж байгаатай холбогдуулах Засгийн газрын тогтоолоор бодлогын баримт бичгүүд батлагдах хүртэл шинээр газар олгохыг 2023-2024 онуудад зогсоосон бөгөөд үүнээс шалтгаалж төлөвлөгөө буурсан үзүүлэлттэй гарч байна. Аймгийн 18 сумын ГЗБ-ын төлөвлөгөөнд тусгагдсанаар 2021 онд 289 иргэнд 14 га газрыг, 2022 онд 783 иргэнд 2359.4 га газрыг, 2023 онд 1220 иргэнд 185922.2 га газрыг, 2024 онд 540 иргэнд 1482.92 га газрыг олголт хийгдсэнээр нийт 2832 иргэнд 189,778.52 га газрыг олголоо. Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг Засгийн газрын 2024 оны 136, 73, 131 дүгээр тогтоолуудаар Говь-Алтай аймгийн хэмжээнд 926 нэгж талбарт 1584.4 га талбай бүхий газар олгохоор батлагдаж ирснээс тийалант үеийн байдлаар 703 нэгж талбар бүхий 1487.4 га газрыг эзэмшүүлж, ашиглуулсан байна. Төлөвлөгөөний биелэлт 75.9%-тай байна. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 19.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэд олон нийтэд нэг цэгээс түргэн шуурхай хүргэх зорилгоор ухаалаг төхөөрөмж (киоск)-ийг 2024.08.01-ний өдрөөс эхлэн хэрэглээнд	70

21.2	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг үргэлжлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Суурин судалгааны ажил хийгдсэн	<p>нэвтрүүлж, 5000 гаруй иргэдэд хэвлэгдэл хуудас гаргаж үйлчилсэн байна.</p> <p>2021 оны 10 сарын 1-ээс <a href="http://www.egaza.gov.mn">www.egaza.gov.mn</a> сайтаар дамжин 2219 цахим хүсэлт хүлээн авч, шийдвэрлэлт 100 хувьтай байна.</p> <p>Аймгийн газар зохион байгуулалтын 2024-2040 оны ерөнхий төлөвлөгөөг орон нутгийн төсөв, ОНХС-ийн нийт 626.6 сая төгрөгөөр "Геоботаник" ХХК-аар гүйцэтгүүлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024.04.25-ны өдрийн "Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай" 09 дүгээр тогтоолоор батлууллаа. Улмаар ИТХ-ын төлөөлөгчдөөс өгсөн саналыг тусгаснаар аймгийн Засаг даргын 2024.06.07-ны өдрийн А/412 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2024.06.14-ний өдөр ажилласан. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын дэргэдэх "Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөл"-ийн 2024.06.11-ний өдрийн хуралдааны шийдвэрээр дэмжиж, 2024.06.14-ний өдрийн ГЗБЕТ/2024-01 дугаар ажил хүлээлцсэн актаар хүлээн авч, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна</p>	100
21.3	Алтай хотын Солонго хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв боловсруулах ажлыг эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хөрөнгө батлагдсан.	<p>Алтай хотын Солонго хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг аймгийн ФНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр нийт 60.0 төгрөгийг тусгаж, 2024 онд 10.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгасан бөгөөд гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг 3 удаа зарласан боловч оролцогч оролцоогүй байна.</p> <p>Иймд аймгийн 2025 оны ОНХС-нд зөвлөх үйчилгээ үзүүлэх ажлын төсөвт өртгийг 120.0 сая төгрөг болгон нэмэгдүүлж батлууллаа.</p>	100
21.4	Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Есөнбулаг, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цээл, Шарга сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хөрөнгө батлагдсан.	<p>Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Есөнбулаг, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цээл, Шарга сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 567.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Вектор Мен" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 70 хувьтай 75.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.</p>	100
Зорилт 22 Бэлчээрийн төлөв байдлыг судлан үр дүнг малчдад хүргэж, бэлчээр зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.					

22.1	Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх, бэлчээрийг зүй зохистой ашиглах талаар малчдыг мэдээлэлтэй болгох	Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн үнэлгээ хийсэн цэгийн тоо	345	<p>Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх журмын дагуу бэлчээрийн газарт 2021 онд 345 цэгт, 2022 онд 347 цэгт, 2023 онд 345 цэгт судалгаа хийгдсэн.</p> <p>2024 онд аймгийн 15 сумын хэмжээнд 6552883 га бэлчээрийн талбайд 2-7 хоногийн хугацаанд улирал бүрийг төлөөлөхүйц фотомониторингийн 287 цэгийн хээрийн судалгааг хийж, гадаргуугийн бүрхцийн зургийг мониторингийн цэг тус бүрээр нэгтгэж боловсруулалтыг "Sample point" программ ашиглан ургамлын бүрхцийн нийт хувь болон заагуур ургамлын бүлгээр ангилан тодорхойлж, ажлын үр дүнг Лэнд менежер программд орууллаа.</p> <p>Нийт мал бэлчээрлэх хоногийн тоо өвөл 120 хоног, намар 90 хоног, хавар 60 хоног, зуны 90 хоног, боломжит даац нь аймгийн дүнгээр 10540554.7 байгаа бөгөөд хонин толгойд шилжүүлснээр 234389 болж бэлчээрийн даац 1704.519 хонин толгойгоор хэтрээгүй үзүүлэлттэй байна.</p>	90
Зорилт 23 Алтай хотын цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, сумдын төвийг усан хангамж, ариутгах татуургын нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттайгаар шийдвэрлэж, бага оврын цэвэрлэх байгууламжтай болгоно.					
23.1	"Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээг үргэлжлүүлж, Алтай сумыг нэгдсэн ус, дулаан хангамж, ариутгах татуургын шугамд холбож, ариутгах татуургын шугамд холбож, цэвэрлэх байгууламжийн болгох ажлыг улсын төсвийн 10,192.7 сая төгрөгийн хөрөнгөөр "Тунгалаг говь транс" ХХК, "Билгүүн од констракшн" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд Ажлын явц 41%-тай 1,565.6 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.	Гүйцэтгэлийн хувь	30%	<p>"Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээг үргэлжлүүлж, Алтай сумыг нэгдсэн ус, дулаан хангамж, ариутгах татуургын шугамд холбож, цэвэрлэх байгууламжийн болгох ажлыг улсын төсвийн 10,192.7 сая төгрөгийн хөрөнгөөр "Тунгалаг говь транс" ХХК, "Билгүүн од констракшн" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд Ажлын явц 41%-тай 1,565.6 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.</p>	100
23.2	Алтай хотын төв цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинэчлэх ажлын зураг төслийг боловсруулж дуусгах	Гүйцэтгэлийн хувь	30%	<p>Алтай хотын төв цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинэчлэх ажлын зураг төслийг 190.0 сая төгрөгөөр "Наран рашаант" ХХК-аар боловсруулж, "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын 2024.03.26-ны өдрийн 262/2024 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр зураг төсөл баталгаажуулж, угсралтад шаардлага хөрөнгө оруулалтыг улсын төсөвт тусуулахаар Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн төсөлд тусуулах сангийн яамны цахим системд 2024.06.23-ны өдөр байршуулж, орон нутгаас сонгогдсон УИХ-ын 10 гишүүдэд 2024.08.19-ний өдрийн 1/1023-1/1033 дугаар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд 2024.08.19-ний өдрийн 1/1037 дугаар албан бичгээр, мөн УИХ-ын гишүүн С.Бямбацогтод 2024.08.29-ний өдрийн</p>	100

					1/1069 дугаар албан бичгээр зураг төслийг хуулбарлан хүргүүлээ.	
23.3	Есенбулаг сумын цэвэр усны 1.5 км шугам сүлжээний шинэчлэн солих ажлыг дуусгах	Гүйцэтгэлийн хувь	Ажлын гүйцэтгэл 70 хувьтай	Гэр хорооллыг дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбох Харзат багийн шугам сүлжээний ажлыг улсын төсвийн 1,160.3 сая төгрөгийн хөрөнгөөр "Энержи плас инженеринг" ХХК гүйцэтгэж байна. Ажлын явц 30%-тай.	50	
23.4	Халиун сумын ундны усан хангамжийн дэд бүтцийн ажлыг дуусгах	Гүйцэтгэлийн хувь	100	Халиун сумын ундны усан хангамжийн дэд бүтцийн ажлыг улсын төсвийн 2,463.0 сая төгрөгөөр "Жаргалант дулаан" ХХК гүйцэтгэж дууссан бөгөөд хүлээж авах улсын комисс ажиллаж ашиглалтад оруулаа.	100	
23.5	Есенбулаг сумын Харзат багийн гэр хорооллыг дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболтын ажлыг үргэлжлүүлэх	Гүйцэтгэлийн хувь	10	Харзат багийн дахин төлөвлөлтийн ажлыг улсын төсвийн 1,160.3 сая төгрөгөөр "Энержи плас инженеринг" ХХК-аар гүйцэтгүүлж, явц 30 хувийн гүйцэтгэлтэй 953.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Шугам сүлжээний трасс дагуу өртсөн хашаа, худаг чөлөөлөх ажиллагааг иргэнтэй тохиролцоонд хүрэхгүй төслийн ажил удаашралтай явагдаж байна.	100	
23.6	Бугат, Шарга, Хөхморьт, Эрдэнэ сумдад бага оврын цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг дуусгах	Эхэлсэн сумын тоо 1 Ашиглалтад орсон сумын тоо 4	Эхэлсэн 4	Эрдэнэ сумын бага оврын цэвэрлэх байгууламжийн ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 576.6 сая төгрөгөөр "Шатаг" ХХК гүйцэтгэж, гэрээт ажил 100% дууссан бөгөөд улсын комисс ажиллаж хүлээлгэн өгсөн. Бугат сумын цэвэрлэх байгууламжийн ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 582.1 сая төгрөгөөр "Жи гоулд" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд 70 хувийн гүйцэтгэлтэй 251.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. Хөхморьт сумын цэвэрлэх байгууламжийн ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 570.5 сая төгрөгөөр "Повер фрикуэнси" ХХК-аар гүйцэтгүүлж, 100 хувь гүйцэтгэн ашиглалтад оруулж, 430.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. Шарга сумын цэвэрлэх байгууламжийн ажлыг 552.4 сая төгрөгөөр "Жи гоулд" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд 5 хувийн явцтай 100.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдоод байна Баян-Уул сумын бага оврын цэвэрлэх байгууламжийн барилгад угсралтын ажлыг 543.04 сая төгрөгөөр "Жи	100	

				<p>Гоулд" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд 10 хувийн гүйцэтгэлтэй 98.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.</p>
<p>Зорилт 24 Уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх орчны нөлөөллийг бууруулах зорилгоор эмнэлэг, сургууль, цэцэрлэг, дотуур байр (нүхэн жорлонтой)-ыг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.</p>	<p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын нийгмийн хариуцлагын хүрээнд нэгдүгээр хүрээнд нэгдүгээр ээлж Алтай, Жаргалан, Цогт, Төгрөг, Баянтоорой тосгоны сургууль, цэцэрлэг, дотуур байрны үеийн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлыг 1,701.4 сая төгрөгийн санхүүжилтээр "Динатос" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд ажил зогссон тул гэрээг цуцлах хүсэлтийг "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ, БЕГ-т тус тус хүсэлт хүргүүлсэн. Дөрөвдүгээр ээлжид Есөнбулаг 8-р цэцэрлэг, Тайшир, Гуулин, Эрдэнэ, Төгрөг, Шарга, Цээл, Хөхморьт сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны үеийн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлыг 1,415.6 сая төгрөгөөр "Шатаг" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд 60 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. гуравдугаар ээлжид хэрэгжүүлэх Баян-Уул, Бигэр, Бугат, Чандмань сумын цэцэрлэг, сургууль, дотуур байрны үеийн жорлонг солих, Есөнбулаг сумын ИСҮТ-ын дотуур байр, 2-р сургуулийн АЦБ-ыг төвлөрсөн шугамд холбох ажлыг 808.2 сая төгрөгөөр "Жи гуолд" ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгууллаа.</p>	<p>Угсралтын ажил эхэлсэн.</p>	<p>Стандартын ариун цэврийн байгууламжтай болсон цэцэрлэгийн тоо</p>	<p>90</p>
<p>24.1</p>	<p>Зорилт.25 Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр баригдаж буй, мөн барихаар төлөвлөсөн барилга байгууламжийн гүйцэтгэлийг бүрэн хэрэгжүүлэх үүднээс талуудын харилцан уялдааг хангаж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хамтран ажиллана.</p>			
<p>25.1</p>	<p>Зооноз өвчин судлалын төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах</p>	<p>50%</p>	<p>Гүйцэтгэлийн хувь</p>	<p>100</p>

25.2	Тайшир сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг эхлүүлэх	Гүйцэтгэлийн хувь	Азийн хөгжлийн банкны 3843-MON, 3844-MON (COL) дугаартай хөнгөлөлттэй зээлээр барихаар төлөвлөгдөж, барилгажих талбайн инженерийн геологийн судалгаа хийгдэж, барилгын ажлын зураг төслийг боловсруулан "Барилгын хөгжлийн төв" ТӨААҮГ-ын экспертизээр хянан баталгаажуулахаар өгсөн. Төслийн санхүүжилт шийдвэрлэж, гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагаа хийгдэхээр хүлээгдэж байна.	100
25.3	Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах	Гүйцэтгэлийн хувь	Хуучин Халдвартын эмнэлгийн барилгыг буулгаж, Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийг шинээр барих ажлыг улсын төсвийн 4,580.0 сая төгрөгөөр "Зорь бүтээ" ХХК-аар гүйцэтгүүлж, ББҚД-82-0010/24 дугаар улсын комиссын дүгнэлтээр ашиглалтад орууллаа.	100
25.4	Тонхил, Цээл сумдад 320 суудалтай сургуулийн барилгыг ашиглалтад оруулах	Гүйцэтгэлийн хувь	Тонхил сумын 320 ортой сургуулийн барилгыг улсын төсвийн 5,599.3 сая төгрөгөөр "Хатан түнгэл" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд 75 хувийн гүйцэтгэлтэй 2,289.3 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Цээл сумын шинэ суурьшлын бүсэд баригдаж буй 320 ортой сургуулийн барилгыг улсын төсвийн 4,989.5 сая төгрөгөөр "Босго толгой" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд 95 хувийн гүйцэтгэлтэй 4,595.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.	90
25.5	Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн барилга, 640 суудалтай шинэ барилгын угсралтын ажлыг эхлүүлэх	Гүйцэтгэлийн хувь	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Есөнбулаг сумын Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн 640 суудалтай өргөтгөлийн барилгын ажлын зураг төслийг "Онц тэнхлэг" ХХК-аар боловруулж, Барилгын хөгжлийн төв" ТӨААҮГ-ын 2024.04.10-ны өдрийн 427/2024 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газарт 3 удаа зохион байгуулж, 11,647.7 сая төгрөгөөр гүйцэтгэхээр "Грэйт майнинг" ХХК шалгарч, 2024.10.15-ны өдөр гэрээ байгуулсан. Хүйтний улирал эхэлсэн тул дулааны улиралд ажил эхлүүлэхээр бэлтгэл ажлууд хийгдэж байна.	100

25.6	<p>Есөнбулаг сумын Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн 100 суудалтай өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулах</p>	Гүйцэтгэлийн хувь	90%	<p>Есөнбулаг сумын Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн 100 суудалтай өргөтгөлийн барилгыг Азийн хөгжлийн банкны 2,474.1 сая төгрөгийн санхүүжилтээр "Эм Ай Эс Эс" ХХК-аар гүйцэтгүүлж, 2024.08.13-ны өдрийн А/507 дугаар захирамжаар комиссын бүрэлдэхүүнийг томилж, үүрэг даалгавар өгч, ашиглалтад оруулахаар хүлээгдэж байна.</p>	100
25.7	<p>Дэлгэр сумын Гуулин тосгоны 160 ортой хичээлийн байрны барилгын ажлыг үргэлжлүүлэх</p>	Гүйцэтгэлийн хувь	40%	<p>Дэлгэр сумын Гуулин тосгоны 160 суудалтай хичээлийн байрны барилгын ажлыг улсын төсвийн 3,119.1 сая төгрөгөөр "Ашид гэгээн өргөө" ХХК-аар гүйцэтгүүлж ашиглалтад орууллаа.</p>	100
25.8	<p>Алтай, Цээл, Чандмань сумд тус бүр 75 ортой, Халиун сумд 100 ортой, Есөнбулаг сумд 320 ортой 6 дугаар цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх</p>	Гүйцэтгэлийн хувь	30-50%	<p>Алтай сумын 75 ортой цэцэрлэгийн барилгыг улсын төсвийн 1,518.9 сая төгрөгөөр "Си би Ай аутсорс" ХХК гүйцэтгэхээр шалгарч, суурийн ажил хийгдэж зогсоон. Улмаар гэрээний үүргийн хэрэгжилт хангагдаагүй тул БШУЯ-ны 2022.11.22-ны өдрийн техникийн зөвлөлийн хурлаар тус ажлын гэрээг цуцлахаар шийдвэрлэж, 2023.06.14-ний өдрийн 1/1805 дугаар албан бичгээр гэрээг цуцалж, хуулийн байгууллагад шилжүүлсэн. Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-аас барилгын суурийн бат бэх хангаагүй буулгаж, дахин суурь цутгах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан. Гүйцэтгэчийг дахин сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаа Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулахаар хүлээгдэж байна.</p> <p>Цээл сумын 75 ортой цэцэрлэгийн барилгыг улсын төсвийн 1,560.6 сая төгрөгөөр "Алегровеер констракшн" ХХК-аар гүйцэтгэж дууссан бөгөөд комисс ажиллуулах бэлтгэл ажил хангагдаж байна.</p> <p>Дэлгэр сумын 75 ортой Цэцэрлэгийн барилгыг "Шатаг" ХХК гүйцэтгэж барилга угсралтын ажлыг батлагдсан зураг төсөл, норм дүрмийн дагуу гүйцэтгэж, 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн КД-31/2022 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад орууллаа.</p> <p>Чандмань сумын 75 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг улсын төсвийн 1,485.9 сая төгрөгөөр "Буман хаус" ХХК гүйцэтгэж, 2024.10.03-ны өдрийн ББКД-82-0008/24 дугаар комиссын дүгнэлтээр ашиглалтад орууллаа.</p> <p>Есөнбулаг сумын 6 дугаар цэцэрлэгийг буулгаж, барих ажлыг улсын төсвийн 4,319.3 сая төгрөгөөр "Жи Ти Кэй Эс"</p>	100

25.9	Төгрөг, Халиун сумд тус бүр 100 ортой дотуур байрны барилгыг ашиглалтад оруулж, Баян-Уул сумын 160 ортой, барилгын ажлыг үргэлжлүүлж, Дэлгэр сумын 100 ортой дотуур байрны барилгын ажлыг эхлүүлэх.	Барилгын ажил эхэлсэн, ашиглалтад орсон барилгын тоо	Дундаж гүйцэтгэл 50%	ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 85 хувийн гүйцэтгэлтэй 3,974.4 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.  Төгрөг сумын 100 ортой, дотуур байрны барилгын ажлыг улсын төсвийн 2,294.4 сая төгрөгөөр "Сэрүүн сайхан алтай" ХХК-аар гүйцэтгүүлж бөгөөд 85 хувийн гүйцэтгэлтэй 1,852.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Халиун сумын 100 ортой, дотуур байрны барилгын ажлыг улсын төсвийн 2,835.1 сая төгрөгөөр "Жаргалант рашаан" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд 75 хувийн гүйцэтгэлтэй 2,100.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Баян-Уул сумын 160 ортой, дотуур байрны барилгын ажлыг улсын төсвийн 5,694.4 сая төгрөгөөр "Эв-эе" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд суурийн цутгалт, 1, 2, 3 дугаар давхрын кэркасны угсралт, дотор, гадна ханын өрлөгийн ажил хийгдэж, 48 хувийн гүйцэтгэлтэй 2,100.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. Улсын төсвийн 2,744.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Дэлгэр сумын 100 ортой дотуур байрны барилга угсралтын ажлыг "Их морьт эрдэнэ" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд 35 хувийн гүйцэтгэлтэй 367.5 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон.	100
25.10	Жаргалан, Төгрөг, Дэлгэр сумд шинээр баригдаж байгаа сургуулийн дотуур байрны барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажлын үлдэгдэл санхүүжилтийг олгож, ашиглалтад бүрэн оруулах	Гүйцэтгэлийн хувь	Ажлын гүйцэтгэл 100 хувьтай	Жаргалан сумд шинээр баригдаж буй сургуулийн барилгын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг улсын төсвийн 342.3 сая төгрөгөөр "Хүслэнт хүдэр" ХХК-аар гүйцэтгүүлж, ашиглалтад оруулж, үлдэгдэл санхүүжилт болох 268.5 сая төгрөгийг бүрэн олгосон. Төгрөг сумын дотуур байрны гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг улсын төсвийн 371.2 сая төгрөгөөр "Динамос" ХХК гүйцэтгэж, 70 хувийн явц гэрээний үүргийн хэрэгжилт хангагдахгүй байгаа тул гэрээг цуцалж, Сангийн яамны хар жагсаалтад оруулах саналыг 2023, 2024 онд БШУЕГ-т хүргүүлсэн. Дэлгэр сумд шинээр баригдсан сургууль, цэцэрлэгийн барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажлыг улсын төсвийн 1,619.1 сая төгрөгөөр "Ай Вай И Зэт групп" ХХК-аар гүйцэтгүүлж, 2023.05.23-ны өдрийн ГАА-КД-06/202 дугаар улсын комиссын дүгнэлтээр байнгын	90

				<p>ашиглалтад оруулж, санхүүжилтийн үлдэгдэл 81.1 сая төгрөгийг бүрэн олголоо.</p>	
25.11	<p>БШУЯ-ны багцаас хэрэгжиж буй Цээл сумд шинээр баригдаж буй цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуухны ажлыг ашиглалтад оруулах</p>	Гүйцэтгэлийн хувь	50%	<p>БШУС-ын багцын 193.8 сая төгрөгийн санхүүжилтээр Цээл сумын цэцэрлэг, соёлын төвийн барилгын гадна ариутгах татуургын ажлыг "Их Морьт Эрдэнэ" ХХК гүйцэтгэж дууссан бөгөөд аймгийн Засаг даргын 2024.12.06-ны өдрийн А/672 дугаар захирамжаар комиссын бүрэлдэхүүн томилогдож, комисс ажиллахаар хүлээгдэж байна.</p>	100
25.12	<p>Есөнбулаг сумын IV сургууль, Бигэр, Баянтоорой тосгон, Цогт сумын сургуулийн спорт заал, Дарив сумд спорт заалны барилгыг ашиглалтад оруулах</p>	Гүйцэтгэлийн хувь	30-70%	<p>Есөнбулаг сумын 4-р сургуулийн спорт заалны барилгыг улсын төсвийн 577.4 сая төгрөгөөр "Сонгомол хаус" ХХК гүйцэтгэх гэрээ байгуулсныг цуцалж, Сангийн яамны хар жагсаалтад оруулж, гүйцэтгэгч дахин сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчээр "Хүслэнт хүдэр" ХХК шалгарч, гэрээ байгуулагдсан гэтэл энэ санхүүжих хөрөнгө Төрийн аудитын албан шаардлага тавигдаж татагдсан. Барилга угсралтын ажлыг дуусгах хөрөнгийг шийдвэрлүүлэхээр УИХ-ын дарга, орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүд, Боловсролын яаманд 2024.08.19-ний өдрийн 1/1023-1/1033 дугаар албан бичгээр хүсэлт уламжиллаа.</p> <p>Тонхил сумын спорт заалны барилгыг "Хүрийн овоо" ХХК гүйцэтгэж, 2024.11.08-ны өдөр улсын комисс ажиллаж, ашиглалтад орууллаа.</p> <p>Бигэр сумын спорт заалны барилгыг 705.3 сая төгрөгөөр "залуу өргөө" ХХК гүйцэтгэж, 73 хувийн гүйцэтгэлтэй 517.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон.</p> <p>Цогт сумын 500 суудалтай спорт заалны барилгыг улсын төсвийн 4,420.2 сая төгрөгөөр "Ашид гэгээн өргөө" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 75 хувийн гүйцэтгэлтэй 3,108.3 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.</p> <p>Баянтоорой тосгоны барилгын ажлыг 700.1 сая төгрөгөөр "Мөнхтооройт" ХХК гүйцэтгэж, 90 хувийн гүйцэтгэлтэй 560.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.</p> <p>Дарив сумын спорт заалны барилгыг улсын 1,711.1 сая төгрөгөөр "Тоонот гранд" ХХК гүйцэтгэж, 42 хувийн гүйцэтгэлтэй 555.4 сая төгрөгийн гүйцэтгэл олгогдсон байна.</p>	70

25.13	Халиун сумын спорт заалны барилгыг зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Барилгын ажлыг эхлүүлэх	Халиун сумын спорт заалны барилгыг улсын төсвийн 1,568.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсан бөгөөд зураг төслийг "Барилга байгууламж" ХХК-аар боловсруулан магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулсан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр 2024.10.03-ны өдөр "Ар-Онгот" ХХК 1,567.4 сая төгрөгөөр шалгарч гэрээ байгуулж, суурийн ул бетон цутгагдаж, дулааны шугам сүлжээний сувагчлаа хийгдэж хүйтний улирал эхэлж, технологийн зогсолт хийгдлээ.	100
25.14	Ахмадын сувиллын барилгын ажлыг үргэлжлүүлэх	Гүйцэтгэлийн хувь	50%	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Ахмадын сувиллын барилгын ажлыг "БГБС" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 50 хувийн гүйцэтгэлтэй 1,403.8 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулинд магадлалын дүн буюу ажлын нийт төсөвт өртөг 3,807.5 сая төгрөгөөр батлагдсан боловч, нэмэлт өртөгийн дүнгээр орон нутагт эрх шилжүүлээгүй, гэрээ байгуулах эсэх нь тодорхойгүй асуудлыг шийдвэрлүүлэхээр Гэр бүл, хөдөлмөр нийгэм хамгааллын яаманд 2024.02.29-ний өдрийн 1/261 дугаар албан бичгээр хүсэлт хүргүүлж, холбогдох албан тушаалтнуудтай холбогдсон бөгөөд тодорхой хариу өгөх хугацаа алдаж, 6 дугаар сард өмнөх оны албан бичигтэй Төрийн аудитын дүгнэлтийг өгсөн. Гэтэл уг дүгнэлтэд нэмэгдсэн өртөгийн дүн зөрүүтэй асуудал гарч, үүссэн асуудлыг шийдвэрлэж, нэмэгдсэн өртөгөөр эрх шилжүүлсэн шийдвэрийг орон нутагт гаргуулахаар 2024.08.08-ны өдрийн 1/996 дугаар албан бичгээр мөн 2024.09.19-ний өдрийн 1/1154 дугаар албан бичгээр хүсэлт уламжилсан. Улмаар холбогдох яамнаас 2024.11.13-ны өдөр tender.gov.mn цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг орон нутагт шилжүүлсэн мэдэгдэл ирснээр 2024.11.16-ны өдөр гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаа зохион байгуулж 2024.12.13-ны өдөр тендер нээхээр хүлээгдэж байна.	50
25.15	Халиун сумд 250 суудалтай соёлын барилгыг төвийн барилгыг ашиглалтад оруулах	Гүйцэтгэлийн хувь	40%	Халиун сумын 250 суудалтай соёлын төвийн барилгыг улсын төсвийн 3,195.1 сая төгрөгөөр "Хонгор буурал" ХХК-аар гүйцэтгэж дууссан бөгөөд 2,779.96 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Комисс ажиллах бэлтгэл хангуулж байна.	100

25.16	Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн ажилчдын 50 айлын орон сууцны барилгын ажлыг эхлүүлэх	Гүйцэтгэлийн хувь	Барилгын ажлыг эхлүүлэх	Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн ажилчдын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар зарласан бөгөөд гүйцэтгэгчээр 5,949.2 сая төгрөгөөр Зэвсэгт хүчний 340 дүгээр цэргийн анги шалгарч, барилгын угсралтын ажлыг эхлүүлдсэн. Тайлант үеийн байдлаар суурийн цутгалт, зоорин багана, шалны төмөр бетоны хучилт хийгдэж, 1,784.8 сая төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажуулж, санхүүжилт олгогдсон. Хүйтэн сэрүүний улирал эхэлж, технологийн зогсолт хийгдсэн байна.	100
25.17	Баян-Уул, Тайшир сумын иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын ажлыг эхлүүлэх	Гүйцэтгэлийн хувь	Барилгын ажлыг эхлүүлэх	Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолоор Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцад тус аймагт хэрэгжүүлэхээр батлагдсан 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулж, гүйцэтгүүлэх эрхийг орон нутагт шилжүүлсэн бөгөөд гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг 1 улиралд багтаан зохион байгуулахад шаардлагатай зураг төсөл, ажлын хэмжээг ХААГ-т хүргүүлсэн. Баян-Уул сумын иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Хонгор буурал" ХХК шалгарч, 2,422.9 сая төгрөгөөр гүйцэтгэхээр 2024.04.11-ний өдөр УТ2401000265 дугаартай ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, 51 хувийн гүйцэтгэлтэй 1,226.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Тайшир сумын иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Буман хаус" ХХК шалгарч, 2,430.4 сая төгрөгөөр гүйцэтгэхээр 2024.04.23-ны өдөр УТ2401000260 дугаартай гэрээг байгуулж, 50.5%-ийн бодит гүйцэтгэлээр гүйцэтгэлтэй 1,227.0 сая төгрөгийн санхүүжилтийг нь баталгаажуулж олгогдсон байна. Хүйтэн сэрүүний улирал эхэлж, технологийн зогсолт хийгдсэн байна.	100
25.18	Гэр бүлийн хүчирхийллийн төвийн "Гүр хамгаалах" байрны барилга угсралтын ажлыг эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хөрөнгө шийдвэрлэгдсэн.	Япон Улсын Засгийн газрын "Өвсний үндэс" хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хөрөнгөөр санхүүжигдэх "Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн барилгыг 696.9 сая төгрөгөөр гүйцэтгэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчээр "Хүслэнт хүдэр" ХХК шалгарч, ажлын явц 95 хувийн гүйцэтгэлтэй, 487.3 сая төгрөгийн санхүүжилт	100

				<p>олгогдсон. Барилгын ажил дуусч, комисс ажиллах бэлтгэл ажлыг хангуулж байна.</p>	
<p>ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ</p>					
<p>ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ТАЙЛАГНАХ*</p>					
<p>2.1</p>	<p>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах</p>	<p>Тайлагналтын тоо</p>	<p>4</p>	<p>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хамаралтай шийдвэрүүдийг картлан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Үүнд: Монгол улсын хууль-5, УИХ-ын 5 тогтоолын 10 заалт, УИХ-ын байнгын хорооны 9 тогтоол, УАБЗ-ийн 6 зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын 31 тогтоолын 45 заалт, ЗГ-ын хуралдааны 31 тэмдэглэл, Засгийн газрын 1 албан даалгаврын хэрэгжилтүүдийг тус тус тооцон Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.</p>	<p>хэлтэст 100</p>
<p>2.2</p>	<p>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах</p>	<p>Тайлагналтын тоо</p>	<p>1</p>	<p>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд ХБТХОХ-т хамаарах 18 зорилт арга хэмжээг карлагдсан бөгөөд тайлант үеийн байдлаар 96.1 хувийн хэрэгжилттэй ХШҮХ-т хүргүүлж, цагалбарын дагуу тайлагнасан байна.</p>	<p>100</p>
<p>2.3</p>	<p>Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцож, тайлагнах</p>	<p>Тайлагналтын тоо</p>	<p>2</p>	<p>Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд 6 бүлгийн 70 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 72 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд хэрэгжилтийг ханган тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 2 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн 81.4 хувиар "Хангалттай" гэж үнэлэгдсэн байна.</p>	<p>100</p>
<p>2.4</p>	<p>Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулан, аймгийн ИТХ-аар батлуулах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>1</p>	<p>Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигт тулгуурлан боловсруулж, Эдийн Засаг хөгжлийн яамны саналыг авч, өөрчлөлтийг тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн байна.</p>	<p>90</p>

2.5	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах, тайлагнах	Тайлагналтын тоо	2	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг аймгийн Засаг даргын Удирдлагын Зөвлөлийн 2024 оны 01 дугаар сарын 26-ны өдрийн 05 дугаар хурлаар хэлэлцүүлэн, Эдийн засаг, хөгжлийн яаманд аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 1/162 дугаар албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын мэдээллийн цахим санд 86.47 хувийн хэрэгжилттэйгээр байршуулан, баталгаажууллаа. Мөн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилт 87.6 хувьтай урьдчилсан байдлаар нэгтгэгдсэн бөгөөд аймгийн Засаг даргын 2021 оны А/170 дугаар захирамжаар батлагдсан журамд заасан хугацаанд тайлагнаж, цахим системд мэдээлэхээр хүлээгдэж байна.	90
2.6	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Тайлагналтын тоо	-	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 2 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн 87.5 хувиар "Хангалттай" гэж үнэлэгдсэн байна.	100
2.7	Аймгийн ИТХ-ын 2024 оны тогтоолын хэрэгжилтийг хангах	Тайлагналтын тоо	-	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны тогтоолоор баталсан 4 шийдвэрийн биелэлтийг 100%-тайгаар үнэлж хүргүүлээ.	100
2.8	Аймгийн Засаг даргын 2024 оны захирамж, албан даалгаврын хэрэгжилтийг хангах	Тайлагналтын тоо	-	Аймгийн Засаг даргын 2024 онд гарсан хэлтэстэй хамааралтай нийт 127 захирамжийн хэрэгжилтийг 3 дугаар улирлын байдлаар тайлагналаа.	100
2.9	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг ханган, тайлагнаж ажиллах	Тайлагналтын тоо	2	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар 92,1 хувиар хэрэгжүүлэн хүргүүлсэн.	100
2.10	Барилга, хот байгуулалтын сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг ханган, тайлагнаж ажиллах	Тайлагналтын тоо	2	Барилга, хот байгуулалтын сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний хагас жилийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 1/796 дугаар албан бичгээр, жилийн эцсийн хэрэгжилт, 2025 оны гэрээнд тусгах санал, сайдын багцын хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэх саналын хамт 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 1/1054 дүгээр албан бичгээр Хот байгуулалт, барилга, хот байгуулалтын яаманд тайланг хүргүүлээ.	100

2.11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг ханган, тайлагнаж ажиллах	Тайлагналтын тоо	1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг 94.7 хувьтай үнэлэн Хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтэс хянуулахаар хүргүүлээд байна.	70
2.12	Эрчим хүчний сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг ханган, тайлагнаж ажиллах	Тайлагналтын тоо	2	Эрчим хүчний сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор тайлагнахаар хүлээгдэж байна.	30
2.13	Зам, тээврийн хөгжлийн сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг ханган, тайлагнаж ажиллах	Тайлагналтын тоо	1	Зам, тээврийн хөгжлийн сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 06-ны 1/1461 дугаар албан бичгээр тайланг хүргүүлээ.	100
2.14	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг ханган, тайлагнаж ажиллах	Тайлагналтын тоо	1	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 96.1%-тай тайлагнан хугацаанд нь хүргүүлэв.	100
2.15	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг ханган, тайлагнаж ажиллах	Тайлагналтын тоо	1	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг 93%-тай тайлагнан хугацаанд нь хүргүүлэв.	100
<b>ГУРАВ.ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>					
<b>ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН БУСАД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ</b>					
3.1	Байгууллага дээр зохион байгуулагдах сарын ажлыг хуваарийн дагуу зохион байгуулах	Зохион байгуулсан тоо	1	Засаг даргын Тамгын газрын байгууллагын сарын ажлын хүрээнд 5 дугаар сард нийт 12 ажлыг зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжилтийг ханган, тайлагнаж ажиллалаа.	100
3.2	Хэлтсийн 2024 оны хөтлөх хэргийн нөрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлж, байгууллагын архивт хүлээлгэж өгөх	Хадгаламжийн нэгжийн тоо	-	Тайлант онд 2023 оны хэлтэст хамааралтай салбаруудын нийт 25 ш түр хадгалах хадгаламжийн бүртгэлийн нэгжийг байгууллагын бичиг хэрэг, архивын эрхлэгчид хүлээлгэн өгсөн.	100
3.3	Албан тушаалтны 2024 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж, тайлагнаж	Мэдүүлэг гаргах албан хаагчийн тоо	-	ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд хэлтсийн дарга ахлах мэргэжилтэн бүхий 5 албан хаагчид хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдүүлж байна.	100

3.4	Хэлтэст хамааралтай ирсэн хариутай бичгийн хариуг хугацаанд нь чанартай хүргүүлэх	Хариутай бичгийн тоо		3 дугаар улирлын байдлаар хэлтэст 808 хугацаатай болон шууд албан бичгүүд ирж, бүртгэн холбогдох мэргэжилтнүүдэд өгч хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна.	100
<b>ДӨРӨВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>					
4.1	Харьяа агентлагуудын үйл ажиллагаанд зөвлөн туслах	Хамрагдсан агентлагийн тоо		Тус хэлтсийн харьяаны нийт 7 агентлагийн үйл ажиллагаанд зөвлөн туслаж, арга зүйн зөвлөгөөг тухай бүр нь өгч ажиллаж байна.	100
4.2 120	Аймгийн хэмжээнд тусгай удирдамжийн дагуу хийгдэх төлөвлөгөөт бус хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах	Хяналт, шалгалтын тоо		Говь-Алтай аймгийн Засаг даргын 2024 оны А/108 дугаар захирамж, аймгийн Засаг даргын орлогчийн баталсан 2024 оны 01 дүгээр удирдамжийн хүрээнд Чандмань сумд байрлах "Секер ресурсус Монголиа" ХХК-ийн Зээгтийн уурхайн үйл ажиллагаанд төлөвлөгөөнд бус шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор улсын байцаагчийн 7 заалт бүхий 1 албан шаардлагыг өгч ажиллав.	100

Төлөвлөгөөг үнэлсэн:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА



Төсвийн Шууд захирагч  
Ш.ЭРДЭНЭБАТ

2024.09.18... А.5

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:  
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ДАРГА

Нэгжийн дарга  
С.МӨНХЖАРГАЛ  
(огноо)

Тайлагнасан:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН, ХЭЛТСИЙН ДАРГА

Нэгжийн дарга  
Л.ХАШ-ЭРДЭНЭ  
(огноо)